

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.10.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид энэ сард 1 удаа хуралдаж 10 асуудлыг хэлэлцэж, 10 тогтоол баталлаа. Үүнд:

Аймгийн ИТХ-ын ээлжит XVI хуралдааныг 10 дугаар сарын 04-ний өдөр хуралдуулж, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн явц, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, аймгийн 2019 оны төсөвт урьд оны үлдэгдлийг нэмж батлах тухай болон тогтоол өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцэхээр шийдвэрлэлээ.

Мөн сум орон нутаг, иргэдээс ирүүлсэн саналыг үндэслэн Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа христийн шашны “Ариун үг баптист” сүм, Орхонтуул суманд буддын шашны Дашгэнпэнлин хийд байгуулж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тус тус 3 жилийн хугацаагаар олгов.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн салбарт 40 гаруй жил үр бүтээлтэй ажиллаж салбарын тогтвортой хөгжлийг хангах, ард иргэдийг эрүүл хүнсээр хангахад оруулсан бодитой хувь нэмрийг нь үнэлж Ерөө сумын “Их шинэстэй” ХХК-ий ерөнхий захирал Сандагийн Ганболдыг Монгол Улсад Атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цолоор, Орхонтуул сумын “Агро шим” ХХК-ий ерөнхий захирал Сүхбаатарын Хийморсанг “Хөдөө аж ахуйн гавьяат зүтгэлтэн цол”-оор, Баруунбүрэн сумын “Бүрэн бумбат” ХХК-ий трактор комбайнч Балжингийн Тогооборыг хөдөө аж ахуйн Гавьяат механикжуулагч цолоор, боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж ирээдүй өсвөр үе, хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх үйлсэд хөдөлмөр зүтгэлээ зориулсныг нь үнэлж Сант сумын ахмад настан ахмад багш Цэнд-Аюушийн Мятагмааг Монгол улсын “Гавьяат багш цол”-оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав. Мөн эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 2, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 4, Цэргийн гавьяаны одонгоор 2, Алтан гадас одонгоор 25, Хөдөлмөрийн хүндэт медалиар 63 иргэнийг шагнуулахаар уламжлав.

Төрөөс боловсрол, соёл урлагийн талаар баримталж буй бодлогыг орон нутагт амжилттай хэрэгжүүлж, боловсрол, соёл урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд залуучуудад чанартай боловсрол олгоход оруулсан хувь нэмрийг нь үнэлж аймгийн Боловсрол, соёл урлагийн газрыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнаснаас гадна боловсрол, барилга, онцгой байдлын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийг аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх энэ сарын 14-нд тус аймагт ажиллаж, Орхонтуул сумын "Агро шим" ХХК-ий тариа хураалт, Орхон сумын аварга ногоочин Б.Халбаатарын ногоо хураалт, Баруунбүрэн сумын "Норбу агко" ХХК-ий услалтын системтэй танилцаж, Сайхан сум дахь Тариалан эрхлэлтийг дэмжих санд ОХУ-аас нийлүүлэгдэж буй өндөр хүчин чадлын трактор комбайныг төвийн бүсийн тариаланчдын төлөөлөлд гардуулан өглөө. Энэ үеэр Ерөнхий сайд У.Хүрэлсүх эх орныхоо хөрс шороонд экологийн хүнсийг үйлдвэрлэж байгаа тариаланчид, ногоочид та бүхэн эгэл баатрууд гэдгийг онцлон тэмдэглэж, тариаланчдад га

тутамд дэмжлэг болгон олгодог 50.000 төгрөгийн урамшууллыг 100.000 болгон дэмжинэ гэдгээ мэдэгдсэн.

Мөн аймгийн Засаг дарга намрын ургац хураалтын явц байдалтай танилцаж, Хушаат суманд ажиллалаа. Тус сумын “Элит үр” ХХК-ий төмс хураалт, шинэ сорт бий болгон гаргаж авч буй лабораторитой танилцав. Мөн “Өгөөж мандал уул” ХХК-ий үтрэмийн талбай дахь шинэ ургацын будаа, хашаажуулалтыг үзэж сонирхлоо.

Аймгийн “Ургацын штаб”-ыг ажиллуулж, цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллийг түргэн шуурхай хүргэн, ургац хураалтын мэдээг нэгтгэн зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 10-р сарын 5-ны байдлаар улаанбуудай 33881 га талбай хураан авч, нэгж га талбайгаас 12.4 цн буюу 42124.48 тонн буюу үр тарианы хураалт 24.8 хувьтай, тосны ургамал 3009 га талбайг хурааж нэгж га талбайгаас 6.7 цн буюу 2025.8 тонн, тэжээлийн ургамал 2345 га талбайг хурааж нэгж га талбайгаас 3.7 цн буюу 866.7 тонн, төмс 1851.5 га талбайд хураалт хийгдэж, нэгж га талбайгаас 117 цн буюу 21733.2 тонн буюу 72.6 хувьтай, хүнсний ногоо 1782.3 га талбайд хураалт хийж, нэгж га талбайгаас 139 цн буюу 24844.2 тонн буюу 70,4 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 150 дугаар тогтоол, “Улсын үзлэг явуулах төв комиссын бүрэлдэхүүн, удирдамжийг батлах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 46 дугаар захирамж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан улсын үзлэг явуулах хуваарийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга М.Цагаанхүү, Төрийн албаны зөвлөлийн ахлах шинжээч А.Цэцэгмаа, Архивын ерөнхий газрын Мэргэжил арга зүйн удирдлагын газрын дарга Б.Цэндсүрэн, Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын эрхлэгч О.Тунгалаг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 09 дүгээр сарын 05-12-ны өдрүүдэд тус аймагт ажилласан. Үзлэгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газар, Зүүнбүрэн, Шаамар сумын Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Онцгой байдлын газрын төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд аргачлал үзүүлэлтийн дагуу үзлэгийг хийж, аймгийн нэгдсэн дүнгээр 92.72 буюу А үнэлгээтэй дүгнэгдлээ. Үүнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 24-ний А/319 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс, албад, сумдын Засаг даргын Тамгын газарт улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний талаар үүрэг чиглэл өгөөд байна.

Сумдын Засаг дарга нарын “Зөвлөлдөх уулзалт” арга хэмжээ Хүдэр суманд 9-р сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн явц байдлын талаар сум тус бүр мэдээлэл хийж, харилцан ярилцаж, хэлэлцлээ. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Сэлэнгэ аймагт хамааралтай нийт 153 зорилтын 318 арга хэмжээ байна. Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр 3 бүлгийн 197 зорилттойгоор боловсруулагдан хэрэгжиж байна. Тус хөтөлбөрт нийт 39 баримт бичгийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэхээр тусгаснаас 2019 оны хагас жилийн байдлаар 31 баримт бичгийг батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 2019 оны хагас жилийн байдлаар 81,8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тосгодын үйл ажиллагааг сайжруулах, төрийн албан хаагчдын чадавхижуулах, харилцан туршлага судлах боломжийг бүрдүүлэх зорилгоор жил бүр уламлал болгон хэрэгжүүлж буй “Тосгодын төрийн албан хаагчдын уулзалт” арга хэмжээг Шаамар сумын Дулаанхаан тосгонд энэ сарын 20-ны өдөр зохион байгуулж, “Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх тухай” сэдвээр сургалт хийлээ.

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын дархлаа, үнэт зүйлс, орон нутгийн хөгжлийн асуудлыг хүүхэд залуучуудад төлөвшүүлэх, эх оронч үзэл санааг

суулгах, уулзалт ярилцлага хийж хэвших, “Монгол цэргийн цэргийн нэгдсэн холбоо”-ны орон нутгийн салбар холбоог байгуулах ажлын хүрээнд Сэлэнгэ аймаг дахь холбооны анхдугаар чуулга уулзалтыг 09 дүгээр сарын 26-ны өдөр АДБ-ийн “Сэлэнгийн долгио” чуулгад зохион байгуулсан. Чуулга уулзалтад аймгийн Засаг дарга Ш.Оргил, “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны удирдах зөвлөлийн гишүүн ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбат, “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны удирдах зөвлөлийн гишүүн Соёлын гавьяат зүтгэлтэн Ж.Цогтсугар, Жагсаалын дарга, бага дарга нарын холбооны төлөөлөл С.Цогтсайхан, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн дарга хошууч Т.Сүхбаатар, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчид, аймагт үйл ажиллагаа явуулж буй үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлага, бие бүрэлдэхүүн, чөлөөнд байгаа ахмад дайчид, залуу үеийн төлөөлөл, орон нутгийн иргэдийн төлөөлөл нийт 400 гаруй хүн оролцлоо. Чуулга уулзалтын төгсгөлд Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, “Сэлэнгийн долгио” чуулгын уран бүтээлчдийн хамтарсан урлагийн тоглолтыг толилуулсан.

Мэргэжлийн хяналтын газрын ажил үйлчилгээний талаар

2019 оны гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Сэлэнгэ аймгийн 11 сумдад хийж, нийт 1950 зөрчил дутагдлыг илрүүлж, 2 аж ахуй нэгжид 5,5 сая төгрөг, 5 иргэнд 1,150,000 төгрөгийн шийдвэрийн арга хэмжээ тооцож, 93 зөвлөмжийн биелэлтийг тооцон ажиллалаа.

2019-2020 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгаж, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтыг хийлээ. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтанд ерөнхий боловсролын 15 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 13 цэцэрлэг, нийт 28 объект хамрагдсан бөгөөд их, дунд эрсдэлийн түвшин 30% буурч, хууль тогтоомжийн хэрэгжилт 73 хувьтай буюу хагас жилийн үнэлгээтэй харьцуулахад 12%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Мандал, Алтанбулаг, Сүхбаатар сумдын зах зээлд хүнсний ногоо нийлүүлдэг ногоочдын төмс, хүнсний ногооноос зохих журмын дагуу дээж авч МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид, Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албатай хамтран Хүдэр, Түшиг, Алтанбулаг, Сүхбаатар сумдын Цөх, Хяраан, Хиагт, Зэлтэр, Орхон, Сэлэнгэ гол мөрний гадаргын усны бохирдолт тодорхойлох зорилгоор уснаас дээж авч ХАБҮЛЛ-т хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн Цагдаагийн газартай хамтарсан ажлын хэсэг 09 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн Ерөө сумын нутагт хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэд, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор хяналт шалгалтыг хийж байна. Шалгалтын явцад 6 иргэний явуулж байсан үйл ажиллагааг таслан зогсоож, албан мэдэгдэл өгч, тухайн газар оронд байсан 97 иргэн, 17 экскаватор, 20 монгол гэр, Зил 131 авто машин, Урал 1, Зил 130 авто машин чиргүүлийн хамт 1, Портер 1, Норт Бенз авто машин 1, суудлын авто машин 25, ковш 2, экскубэр 5, гитаран буу 2-ийг тус тус албадан буулгаж Өлөнтийн хяналтын постонд 12 экскаватор, 1 бульдозер, 3 ковш, 3 экскубэрийг хүлээлгэн өгч ажиллалаа.

Стандартчлал, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар

Аж ахуйн нэгж, байгууллагуудад Монгол Улсын Хэмжил зүйн тухай хуулийн хэрэгжилт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, ашиглалт, худалдан авагчид дутуу савлагаатай, хаяг шошгололтын зөрчилтэй бүтээгдэхүүнийг худалдан авч, эдийн засгийн хохирол амсахаас урьдчилан сэргийлэх, хууль эрхзүйн мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор аймгийн МХГ, СХЗХ-ийн даргын хамтарсан удирдамжийн дагуу Сүхбаатар суманд савласан бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулдаг 21 аж ахуйн нэгж, иргэнийг хамрууллаа. Шалгалтын явцад хүнсний бүтээгдэхүүн савласан гялгар уутны хэмжээг нийт 28 уутыг зориулалтын багажаар хэмжихэд 80 орчим хувь нь хориглосон уутыг хэрэглэж байгааг илрүүлэн анхааруулга, мэдээллийг өгч

ажиллалаа. Тайлант сард Сайхан, Мандал, Сүхбаатар, Шаамар, Алтанбулаг, Ерөө сумын Бугант тосгоны нийт 14 аж ахуйн нэгж, иргэний 15 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 11 аж ахуйн нэгж, иргэний 12 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон. Үүнд: 3 минимаркет, хүнсний дэлгүүр 4, хүнсний мухлаг 1, зоогийн газар 1, авто засварын газар 1, таксийн үйлчилгээ 1 тус тус хамрагдсан.

Сүхбаатар-Алтанбулаг сумын хооронд зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлдэг "Их овооны зам" ХХК-ийн үйл ажиллагаанд "Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5122:2013" стандартын дагуу тохирлын үнэлгээг аймгийн МХГ, Замын цагдаагийн тасаг, Автотээврийн төвийн улсын байцаагчидтай хамтран хийлээ.

Бүтээгдэхүүн баталгаажуулалтын чиглэлээр Хүдэр сумын "Хурниад Хүдэр" ХХК-д үйлдвэрлэсэн "Талст Хүдэр" нэрийн зөгийн бал боловсруулах цехийн үйл ажиллагаанд дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт хийж, Дархан-Уул аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн Сорилтын лабораторид шинжлүүлсэн сорилтын дүнг үндэслэн тохирлын гэрчилгээ олголоо.

Стандартын салбар сангаас 14 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 6 нэрийн 16 стандартын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, 4 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 1 нэрийн 4 стандартын борлуулалт хийж, Эзлэхүүн хэмжлийн төрлөөр 3 байгууллагын хүсэлт дуудлагын дагуу шатахуун түгээгүүрийг, "Спирт, бал бурам" ХХК-ий архины 2 тоолуурыг баталгаажуулж, УЦУОШТөв болон нэгдсэн эмнэлэг, мал эмнэлэгийн 27 шилэн хэмжүүрт шалгалт тохируулга хийсэн.

Механик хэмжлийн төрлөөр Сайхан, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг сумдын "Гачуурт" ХХК-ий 17 автопүү, эмнэлэгийн жин 7, элеваторын жин 1, худалдааны газрын 24 нийт 49 жин шалган баталгаажуулж, массын хэмжлийн төрлөөр "Алтан тариа" ХХК-ны технологи, чанар хяналт сорилтын лаборатори, "ТЭД" сан, УЦУОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лаборатори, Алтанбулаг Эрүүл мэндийн төвийн 14 электрон жин, 10 ш туухайд нийт 21 хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийлээ. Цахилгааны хэмжлийн төрлөөр 2019 оны гэрээний дагуу Сайхан, Дулаанхаан, Шаамар суманд "ДСЦТС" ХК-ий лабораторитой хамтран 3 фазын 41 цахилгааны тоолуур, 1 фазын 300 цахилгааны тоолуур, дулаан, даралтын хэмжлийн төрлөөр Алтанбулаг, Сант, Бугант сумын Эрүүл мэндийн төв, Шаамар сумын мал эмнэлэгийн 6 ш эмнэлэгийн термометр, 7 ш цусны даралтын аппаратыг ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Тайлант сард 13499 баримтаар 59.2 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэж, аймгийн төсвийн гүйцэтгэлийн 8-р сарын нэгдсэн мэдээг гаргаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулсан.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		53.112.589.3	51.347.558.5	96.7
1.1	Орон нутгийн төсвийн орлого	14.437.786.3	13.512.588.7	93.6
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	11.272.405.8	9.841.476.6	87.3
	Сумдын төсвийн орлого	3.165.380.5	3.671.112.1	116.0
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	3.648.428.7	3.648.428.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	29.707.070.2	29.707.080.2	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	3.961.941.6	3.568.364.5	90.1
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/			

1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	131.825.9	131.825.9	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	220.140.5	142.817.8	64.9
1.8	Сум хөгжүүлэх сан /орлого/	1.005.396.1	636.452.7	63.3
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		64.979.714.9	55.663.709.8	85.7
Орон нутгийн төсвийн нийт зарлага		64.979.714.9	55.663.709.8	85.7
Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага		12.849.699.3	9.550.980.1	74.3
Сумдын орон нутгийн хөгжлийн сан		1.713.977.5	876.279.6	51.1
Сумдын сум хөгжүүлэх сан		1.005.396.1	655.731.0	65.2
Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага		7.399.943.9	4.690.863.2	63.4
Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт		600.000.0	383.340.3	63.9
Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт		549.000.0	19.550.0	3.6
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан		1.874.124.1	1.482.093.5	79.1
Халамжийн сан		323.091.0	187.235.0	58.0
Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага		4.159.019.8	2.404.320.2	57.8
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		217.800.0	214.324.2	98.4
Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		33.102.579.3	30.016.458.0	90.7
Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		582.158.9	550.677.9	94.6
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		38.710.129.1	38.710.129.1	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	8.908.830.9	8.908.830.9	100.0
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		1.782.267.1	1.782.267.1	100.0
Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд		94.228.0	94.228.0	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд				
Хөрөнгө оруулалтын зардалд		1.688.039.1	1.688.039.1	100.0
Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		2.215.274.7	1.691.869.4	76.4
Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд		1.874.124.1	1.350.718.8	72.1
Усны татаас		21.650.6	21.650.6	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд		319.500.0	319.500.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	29.166.951.1	29.166.951.1	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	540.119.1	540.119.1	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/		29.166.951.1	29.166.951.1	100.0
- Ерөнхий боловсролын сургууль		16.024.313.2	16.024.313.2	100.0
- Хүүхдийн цэцэрлэг		8.553.778.1	8.553.778.1	100.0
- Эрүүл мэндийн байгууллага		4.504.254.8	4.504.254.8	100.0
- Газрын кадастрын байгууллага		310.552.9	310.552.9	100.0
- Хүүхдийн байгууллага		314.171.2	314.171.2	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1.005.396.1	636.452.7	63.3

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2018 08- сар	2019 08- сар	2019- 08 2018-08 төгрөгөөр
1.ХҮНСНИЙ БАРАА			

1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 100	1 200	109.1
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 300	109.1
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 500	7 800	120.0
	Үхрийн мах /кг/	7 500	8 800	117.3
	Адууны мах /кг/	5 800	7 000	120.7
	Ямааны мах /кг/	5500	7 000	127.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	3500	4 000	114.3
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	800	1 000	125.0
	Сүү / савласан, л/	2 600	2 700	103.8
	Тараг /задгай, л/	1 000	1 300	130.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	15 000	115.4
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 200	1 000	83.3
	Лууван /кг/	1200	1 100	91.7
	Манжин /кг/	1500	1500	100.0
	Байцаа /кг/	1500	1200	80.0
	Сонгино /кг/	1500	1500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 800	121.7
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 750	106.4
	Бензин А - 92	1 795	1 850	103.1
	Дизелийн түлш	2 105	2 370	112.6

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2019 оны 8-р сард 345 холбогдогчтой 1642,5 сая төгрөгийн хохиролтой, 528 гэмт хэрэг бүртгэгдэж, урьд оны мөн үеэс 36 хэргээр буюу 7.3 хувиар өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 48,0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,7 хувиар өссөн байна. Мөн аймгийн хэмжээнд нийт 18587 зөрчил илрүүлсэн нь өмнөх оны мөн үеэр 3920 зөрчлөөр буюу 28,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 9 дүгээр сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 262 бичиж, лавлагаа 3, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 139, лавлагаа 20 олгосон. Иргэний бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэл 141, гэрлэлтийн бүртгэл 50, гэрлэлт цуцалсны бүртгэл 11, үрчлэлт 10, эцэг тогтоолт 46, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 9, нас баралт 48 бүртгэгдэж, иргэний үнэмлэх олголт 764, гадаад паспорт олголт 80, ОХУ-ын хил нэвтрэх хавсралтыг 2921 хүнд олгон үйлчилж, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 165, хот доторх шилжилт хөдөлгөөн 210 тус тус бүртгэгдсэн.

Архивын тасгаас баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Ус, цаг уур орчны шинжилгээний албаны 9хн-д ЭШТБ ажлыг хийж 369 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэсэн. Мөн 8 хөмрөгийн 45-хн-ий 5120 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 4505, хүний нэр 24259, газарзүй нэр 2114, байгууллагын нэр 2819-г шивжсэн. Мөн 10 хөмрөгийн 78 хн-ийн 6479 хуудас баримтыг мастер хувьтай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Ард иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын баримтаас цахим хэлбэрээр 78, мастер хувиас 37 цаасан суурьтай баримтаас 39 нийт 154 лавлагаа, мөн магадлагаа тодорхойлолт 20-г тус тус гарган үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

2019-2020 оны хичээлийн жилийн нээлтийг 09 дүгээр сарын 01-ний ням гарагт сургууль, цэцэрлэг бүр зохион байгуулж аймгийн хэмжээнд 45 цэцэрлэгт 2 настай элсэгч 1938, нийт 8954 гаруй хүүхэд, ерөнхий боловсролын 34 сургуулийн 1 дүгээр ангид 2200 гаруй хүүхэд шинээр элсэж, нийт урьдчилсан тоогоор 21000 орчим хүүхэд суралцаж байна. 2019-2020 оны хичээлийн жилийн нээлтийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Үндэсний олон нийтийн телевизээр 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 10.00 цагт “Тусгаар тогтнол-Эх оронч үзэл” сэдвээр нээлттэй хичээл зааж, сургуулиуд сурагчдад хичээлийг хүргэх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 14 тоот тогтоолоор Боловсрол, соёл, урлагийн газар үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг 09 дүгээр сарын 17-ны өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Ойн арга хэмжээний хүрээнд хүндэтгэлийн баярын хурал, “Багш шавийн дуулал” урлагийн тоглолт болон салбарын байгууллагуудын “Нэгэн жарны түүх” үзэсгэлэнг Партизаны талбайд зохион байгууллаа. Үзэсгэлэнд 17 сумын ЕБ 34 сургууль, 40 цэцэрлэг, 19 соёлын төв, Сүхбаатар сум дахь аймгийн нийтийн номын сан, Мандал сум дахь аймгийн нийтийн номын сан, “Сэлэнгийн долгио” чуулга, “Мөнгөн хараа” чуулга, аймгийн нэгдсэн музей гэх мэт нийт 98 байгууллага оролцсоноос гадна “Аз хур” номын их дэлгүүртэй хамтран иргэдэд 75 хүртэл хувийн хямдралтай худалдаа боллоо. Мөн аймгийн шилдэг сургуулиар Мандал сумын “Билэг ДБ” дунд сургууль, шилдэг цэцэрлэгээр Баянгол сумын цэцэрлэг, шилдэг Соёлын төвөөр Зүүнбүрэн сумын Соёлын төв шалгарлаа. Олон нийтийн санал асуулгын дүнд 10 шилдэг багшийг тодорүүлсан. “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн багш, Монгол Улсын шилдэг багшаар 2 удаа шалгарсан Д.Далайсүрэн, “Сэлэнгийн долгио” чуулгын ахмад бүжигчин Дэлгэрцэцэг нар шагнагдсан.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд эх хэлний сургалтыг дэмжих зорилгоор 5 төрлийн 12.554.160 төгрөгийн өртөг бүхий хүүхдийн уран зохиолын номыг 34 сургуульд нийлүүлсэн.

“Швейцарын хөгжлийн агентлагийн “Монгол ногоо” төслийн хүрээнд “Хүүхдийн хоол-эрүүл мэнд” сургалтыг зохион байгуулж, дотуур байрны болон цэцэрлэгийн 59 тогоочийг хамруулсан. Бэлчир бүсийн гадаад хэлний багш нарын сайжруулсан хөтөлбөрийн дагуу жилийн болон нэгж хичээлийн төлөвлөлт боловсруулах арга зүйн дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж гадаад хэлний 25 багш хамрагдсан.

БНСУ-ын Жэжү тусгай мужийн Боловсролын газраас Сүхбаатар сумын 4-р сургуульд 152.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мэдээллийн технологийн сургалтын иж бүрэн кабинетыг нээж багш, сурагчийн ширээ, сандал, компьютер, ухаалаг самбар, ханын шкаф зэрэг тоног төхөөрөмж, эд хогшлын угсралтыг ажлыг “MS KOREA” компани хийж гүйцэтгэлээ. Мөн аймгийн ерөнхий боловсролын 9 сургуульд 85.000.000 төгрөгийн өртөг бүхий 28 ширхэг ус шүүгчийг хандивласан

2019 оны 09 дүгээр сарын 06-наас 15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо 21 аймаг, 9 дүүргийн хүүхдүүдийн дунд зохион байгуулагдсан хүүхдийн спортын наадамд спортын 18 төрлөөр нийт 209 тамирчин, багш дасгалжуулагч нар аймаг орон нутгаа төлөөлөн оролцож, 6 алт 10 мөнгө 11 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн.

2019 оны Уулын дугуйн өсвөр үе, залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг анх удаа аймагтаа зохион байгууллаа. Тэмцээнд 13 байгууллагын 56 тамирчин 4 насны ангиллаар хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс багийн дүнгээр 1-р байранд Төв аймаг, 2-р байранд Сүхбаатар аймаг, 3-р байранд Спортын төв сургууль тус тус шалгарсан.

2.Эрүүл мэндийн чиглэлээр

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 9-р сарын 17-ны өдрийн 11/66 тоотыг үндэслэн Дархлаажуулалтын үндэсний товлалыг шинэчлэн батлах тогтоолын дагуу 7, 15 настай хүүхдүүдэд сахуу, татрангийн эсрэг вакциныг дархлал сэргээх тунгаар хийх үйл ажиллагааг Ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж, аймгийн хэмжээнд нийт 3282 хүүхдүүдийг хамруулсан. Мөн “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагын 238 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдыг хепатит В эсрэг вакцины 1-р тунд хамруулсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчид болон хоригдож буй 40 хүнд нарийн мэргэжлийн эмч нарын баг /Дотор, сэтгэц, мэдрэл эхо, цусны ерөнхий шинжилгээ, чих хамар хоолой, рентген аппаратаар зураг / гэх мэт эмч нарын баг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Хүүхдэд зонхилон тохиолдох амьсгалын эрхтний эмгэгүүдийн орчин үеийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, хяналтын зарчим” сэдэвт 1 кредитийн сургалтыг сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 70 эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан.

Австрали улсын Гриффитийн их сургуулийн доктор, профессор Хамиш, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Баянгол, Баруунбүрэн сумын эрүүл мэндийн төвүүдэд осол гэмтлийн үед анхан шатны тусламж үзүүлэх багцийг хүлээлгэн өгөх, “Эх барихын яаралтай тусламжийн сургалтын өртөө, Зайн оношлогооны сүлжээний тоног төхөөрөмж”-ийг хүлээлгэн өгөх арга хэмжээг тус тус зохион байгуулсан.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 08 дугаар сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүд 637 байсан бол 278 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 137 ажлын байранд 135 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 73 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 707 болсон байна

Нийгмийн халамжийн сангаас 9 дүгээр сарын байдлаар 39815 иргэнд 11,229,290.4 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

-Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2567 иргэнд 3,615,281.6 мянган төгрөг

-Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1733 иргэнд 1,009,357.6 мянган төгрөг

-Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1682 иргэнд 651,491.6 мянган төгрөг

-Онцгой тохиолдлын тэтгэмж 58 иргэнд 69,600.0 мянган төгрөг

-Ахмад настны тусламж, хөнгөлөлт 3989 иргэнд 418,746.5 мянган төгрөг

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 589 иргэнд 139,698.1 мянган төгрөг

-Жирэмсэн эхийн тэтгэмж 2596 эхэд 327,998.4 мянган төгрөг

-Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 80 иргэнд 62,642.6 мянган төгрөг

-Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8851 иргэнд 1,156,900.0 мянган төгрөг

-Насны хишиг 5022 иргэнд 720,790.0 мянган төгрөг
-Цалинтай ээж хөтөлбөр 6400 иргэнд 2,254,624.6 мянган төгрөг
-Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжинд 223 иргэнд 193,644.8 мянган төгрөг
-Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 1050 өрхөд 6025 иргэнд 608,514.6 мянган төгрөг

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 4 дуудлага ирж, хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлсэн. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлөөр ангилбал:

- Бие махбодын хүчирхийлэл-0
- Үл хайхрах хүчирхийлэл-2
- Сэтгэл санаа-1
- Бэлгийн хүчирхийлэл-1

Бэлгийн хүчирхийллийн хохирогч 3 хүүхдийн урьдчилсан хэлэлцүүлгийн шүүх хуралдаан болон байцаалтанд 4 удаа хууль ёсны төлөөлөгчөөр оролцсон.

“Гэр бүлийн зөвлөгөө өгөх танхим”-аар бэлгийн хүчирхийлэлд өртсөн 2, хулгайн хэрэгт холбогдсон 1 хүүхэд, зан төлөвийн өөрчлөлттэй 1 насанд хүрэгч, нийт 4 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 5 баар, 4 ресторан, 8 зочид буудалд насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, 17 суманд удирдамжийн хүрээнд давхардсан тоогоор 12 удаа хяналт шалгалт зохион байгуулж, 16 баар, 18 зочид буудал, 19 зоогийн газар, 28 хүнсний дэлгүүрт хяналт тавин ажиллаж, сэрэмжлүүлэг гарын авлагыг тараасан.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээний шинэ нэр төрлүүдийг бий болгох суурь үзүүлэлтийг тодорхойлох зорилгоор хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт 17 сум, 6 тосгоны 56 багийн 270 өрхөөс Сүхбаатар сумын 47 өрхийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, нийт 49 насанд хүрэгч, 74 хүүхдэд сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн.

“Нийгмийг өөрчлөх боловсрол” залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд Залуу гэр бүлүүдийг хүүхэддээ тавих анхаарал халамжаа сайжруулан, хүүхэддээ үлгэр ярьж өгөх “Үлгэрч аав, ээж” тэмцээнийг зохион байгуулж, өдөр бүр хүүхэддээ үлгэр уншиж хэвшсэн 5 аав, ээжийг тодруулан шагнаж, урамшуулсан. Ажлын байр болон хүрээлэн буй орчиндоо хоггүй цэвэр, цэмцгэр байх санаачилга гарган хог хаягдлыг түүлгэх, орчныг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ял эдэлж буй залууст болон албан байгууллагуудад “Халамжтай аав” сургалтыг зохион байгуулж 25 залуусыг хамруулсан. “Бусдадаа урам хайрлая” хөдөлгөөнийг өрнүүлж цахим орчинд эерэг хандлага, эерэг сэтгэгдэл хөдөлгөөнийг уриалж, нийт 9 байгууллага хамт олон нэгдсэн.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2019 оны 09 дүгээр сарын байдлаар 25,6 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс өссөн дүнгээр 27,3 тэр бум төгрөгийн орлого төвлөрүүлж, 106.67 хувийн биелэлттэй ажилласан.

Тэтгэврийн даатгалын сангаас 16779 тэтгэвэр авагчдад 46774392 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 4818 хүнд 1972010 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 274 хүнд 782911 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 360 хүнд 523374 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 9-р сард 3 хурал хуралдаж, 300 иргэний материалыг хэлэлцэн 20 иргэнийг цуцалж, 49 иргэн шинээр групп тогтоолгож, 231 иргэн актаа сунгуулсан.

Тайлант сард нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 805 иргэд, даатгуулагчдад гарган түргэн шуурхай үйлчиллээ.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2019 оны ургац хураалт, 2020 оны улаанбуудайн үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор 30 аж ахуйн нэгжийн 20,0 мянган га талбайд сортын хянан баталгаа хийж Ургацын улсын комиссын шийдвэрийн дагуу улаанбуудайн үр авах ажлыг эхлүүлэн сумдад зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.

“Атар 60” ажлын хүрээнд “Баатруудаараа бахархъя” уулзалт нэвтрүүлгийг ХХААХҮЯ, МҮОНТ-тэй хамтран Сайхан суманд зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” 285 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын “2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 07 тоот албан даалгавар, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын “Цаг үеийн ажлыг эрчимжүүлэх” ажлын хэрэгжилтийг сумдад зохион байгуулж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд малчдын түвшинд 142,1 мянган тонн байгалийн хадлан, 37,9 мянган тонн үйлдвэрийн тэжээл бэлтгэхээс байгалийн хадлан 115,0 мянган тонн, ногоон тэжээл 4352 тонн бэлтгэсэн нь малчдын түвшинд 80,9 хувьтай байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 01 тоот “Мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих” нэгдсэн ажлын удирдамжийн дагуу сумдын мал эмнэлгийн тасгаас 7 төрлийн мэдээ, мэдээлэлийг сар, улирлаар авч нэгтгэн Мал эмнэлгийн ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлж, мэдээллийн сан бүрдүүлсэн.

Аймгийн хэмжээнд 17 суманд 45 мал эмнэлгийн үржлийн нэгж, орон нутгийн мал сүрэгт мал амьтны эрүүл мэндийн үзлэг хийж байна. Тайлант хугацаанд адуу 95239, үхэр 201214, тэмээ 480, хонь 691629, ямаа 512983 нийт 1,5 сая толгой мал хамрагдсан.

Аймгийн Засаг даргын 2019 оны “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ явуулах тухай” А/154 тоот захирамжаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд МУЗГ-ын 225-р тогтоолын 3 дугаар улирлын байдлаар улсаас санхүүжүүлэх тарилганд 561.5 мянган толгой мал, амьтан, орон нутгаас санхүүжүүлэх тарилганд 271.0 мянган толгой мал, амьтан, иргэд, ААН-ээс төлбөр авах тарилганд 352.5.5 мянган толгой мал, амьтан буюу технологит хугацаанд давхардсан тоогоор нийт 1184.0 толгой мал, амьтан буюу 100.4 хувийг хамруулаад байна.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Сэлэнгэ аймагт барилгын салбар үүсэж, хөгжсэний түүхт 60 жилийн ойн арга хэмжээг 9-р сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Баярын хурлын үеэр барилгын салбарт ажиллаж байсан ахмадууд болон одоо ажиллаж буй ажилтан албан хаагчдад улс, аймаг, орон нутгийн шагналын гардуулан өглөө.

Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт шинээр газар эзэмших 5 иргэн,эрх баталгаажуулах 4 иргэн, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх- 20 иргэн, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт гарсан 4 иргэн, газар эзэмших эрхийн Э дугаар авах хүсэлт гаргасан 42 өргөдөл хүсэлтийг хүлээн авсан. Аймгийн Засаг даргын 5 удаагийн захирамжаар нийт 21 иргэний газар эзэмших эрхийг шилжүүлж, 11 иргэнд шинээр газар өмчлүүлж, 5 иргэний хүсэлтээр газар эзэмших эрхийг хэсэгчилэн шилжүүлж, 2 иргэний газар эзэмших эрхийг баталгаажуулж хуулийн хугацаанд өргөдлийг шийдвэрлэв. Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 32

иргэн, 4 аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээв. Тус сард 34 иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулав. Банк болон банк санхүүгийн байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалан зээл авч байгаа 24 иргэн аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн барьцааны бүртгэлийг газрын цахим биржид бүртгэлжүүлэн 10 иргэн аж ахуйн нэгжийн барьцааг чөлөөлж газрын мэдээлийн санд холбон ажилласан.

Газрын төлбөрийн орлогыг бүрдүүлэх ажлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших, ашиглах гэрээг шинэчлэн байгуулаж, холбогдох иргэн аж ахуйн нэгж байгууллагад төлбөрийн нэхэмжлэхийг хүргүүлэн 10 дугаар сарын 25-ны дотор газрын төлбөр барагдуулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Сүхбаатар сумын Боргүвээ 5-р багт 7 нэгж талбар, Баянхаан 4-р баг 3 нэгж талбар, Салхит 3-р багт 4 нэгж талбарыг хаягжуулалтын журмын дагуу дугаарлан, Хонгор морьт 1-р баг багт 3 нэгж талбарт нэр өгч аймгийн мэдээллийн санд бүртгэж, Сүхбаатар суманд гарсан зөрчил маргааны дагуу 6 нэгж талбар дээр хяналтын хэмжилт хийж, нийтийн эзэмшил газрыг зөвшөөрөлгүй ашигласан өргөдөл гомдлын дагуу 2 иргэнд мэдэгдэх хуудас өгч ажилласан. Аймгийн засаг даргын А/270 тоот захирамжийн дагуу 2019 оны 09 дугаар сарын 17-20 ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран Ерөө сумын нутаг дэвсгэрт нөхөн сэргээлт хийсэн талбайнуудад Дрон ашиглан гүйцэтгэсэн нөхөн сэргээлтүүдийн 3д зургийг бэлдэн өгч ажилласан.5-н аж ахуй нэгж байгууллагад шаардлагатай байгаа дэвсгэр зураг хэвлэж өгсөн.

Долоо. Байгаль орчны чиглэлээр

Өнгөрсөн 7, 8-р сард ОХУ-д гарсан их хэмжээний түймрийн улмаас зарим амьтан дайжин манай хил орчмын бүсийн сумд руу орж ирсэн ба ойд идэш тэжээлийн зүйлс хомс, хуш модны самар ургаагүй, жимс байхгүй/ болсон зэрэг шалтгааны улмаас баавгай хөвчөөс бууж голын эрэг орчмын бургасан шугуй, суурьшлын бүс руу орж айлын мал идэж, хүн рүү халдах явдал гарч байна. Иймд хүн, малыг баавгайгаас хамгаалах сэрэмжүүлэх зөвлөмжийг сумдад хүргүүлсэн.

Одоогийн байдлаар Хушаат суманд 6 баавгай, Хүдэр суманд 6 баавгай, Сайхан суманд 1, Жавхлант суманд 1 баавгай, Ерөө голын ногоон тохойд 2 бамбарууштай 1 баавгай бууж ирсэн. Хушаат суманд 30 гаруй ямаа, Хүдэр суманд 10 гаруй бог мал, Жавхлант суманд 1 гахай идсэн мэдээтэй байна.

Хараа-Ерөө, Сэлэнгэ голын сав газрын захиргаатай хамтран аймгийн хэмжээнд усны тооллогын ажлыг гүйцэтгэсэн

Монгол Улсын Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2019-2020 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж гаргаасан. Зуншлагын байдал 2019 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 80 гаруй хувьд нь хэвийн, 10 орчим хувьд дунд, өөрөөр хэлбэл нутгийн 80 гаруй хувьд нь өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой байна.

Харин нутгийн 10 орчим хувьд нь бэлчээрийн боломж муу байгаа тул өөр нутагт отор нүүдэл хийх, нэмэгдэл тэжээл бэлтгэх, малын тоог бууруулах зэргээр мал өвөлжилт, хаваржилтын ажлыг эртнээс анхаарах шаардлагатай. Алтанбулаг сумын Бүргэдэй, Суварга, Мандал сумын Баянсуудал, Орхон сумын Орхон, Сайхан сумын Гавшгай, Шаамар сумын Охьхөндий, Сүхбаатар сумын Боргүвээ багуудын нутгаар бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн тул дээрх сумдад мал өвөлжих, хаваржих нөхцөл хүндрэхээр байна. Иймд дээрх сумдад бэлчээрийн зохицуулалт хийх ажлыг өөрсдийн дотоод нөөц бололцоон дээр тулгуурлан оновчтой, шуурхай зохион байгуулах зөвлөхийг хүргүүлээд байна .

Найм.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Сэлэнгэ аймаг дахь SECIM (Нэмүү өртгийн сүлжээ төсөл)-ийн байгууллага, сумын Засаг даргын тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлэгийн тасаг хамтран малчдад зориулсан сургалт мэдээллийн ажлыг 8-р сарын 23-ны өдөр Ивцэг чиглэлийн 20 өрхийн нийт 30 гаруй иргэдэд зохион байгуулж, өртгийн сүлжээг хөгжүүлэх замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг бий болгох, хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл, малчдын бүлэг хоршоо бий болгох тухай, төсөл бичихэд анхаарах зүйлс, төслийн бүтэц, бэлчээр ашиглагчдын холбоо, бэлчээр ашиглалтын тухай, малын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хадлан тэжээлийн зөвшөөрөл олгох, малын шилжилт хөдөлгөөн, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, угаалга, тарилга, туулгалтын талаар болон цаг үеийн мэдээлэл хийж гарын авлага, зөвлөмж материал тараан малчидад тулгарч байгаа асуудал, санал, зөвлөмжийг сонслоо.

“Тэргүүн тэлмэн” ХХК, “Хишиг-Өндөр Ой” БГБХН, “Ногоон ирээдүй” нөхөрлөл, “Гав хад-Өрлөг хангай” БГБХН-үүдийн арчилгааны огтлол буюу тохируулах огтлолын талбай тусгаарлалтын ажилд хяналт тавин ажиллаж, Улаан бургасанд 09-р сарын 03-нд түймэр гарсныг 09 дүгээр сарын 04-нд бүрэн унтраасан.

Энэ хичээлийн жилд ЕБС-ийн 1-р ангид элсэн суралцах 83 сурагч суралцахаар бүртгүүлсэн. Сургуулийн хичээлийн нээлтийг зохион байгуулж, УИХ-ын гишүүн Н.Оюундарийн гарын бэлгийг 1 дүгээр ангид элсэн орж байгаа нийт сурагчдад гардуулан өгсөн.

2019-2020 оны хичээлийн жилд сумын 1-р цэцэрлэгт хамран сургах тойргийн 1 дүгээр багийн 186 хүүхэд, 3 дугаар багийн 29 хүүхэд нийт 215 хүүхэд байдгаас 209 хүүхэд буюу 97,2 хувийг, 2 дугаар цэцэрлэгт өдрийн 5 бүлэг, 24-ийн 1 бүлэгт 145 бүртгэн хамруулж байна.

Зүүнбүрэн сум:

Монгол Улсын Боловсролын тэргүүний ажилтан, гэр бүл, сэтгэл судлалын ухааны доктор сэтгэл зүйч Г.Наранбаатарыг урьж, төрийн албан хаагчдад зориулан “Үнэ цэнэтэй ажилтан байх”, “Тогтвортой гэр бүл”, “Тогтвортой ажил амьдрал”, “Эерэг хандлагын ач холбогдол”, “Шалтаг биш үр дүн гаргах нь” сэдвээр, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад “Эерэг хандлага ач холбогдол”, “Аав ээжтэйгээ хэрхэн зөв харьцаж, ойлгох бэ?”, “Өөртөө итгэлтэй байдал” зэрэг сэдвээр сургалт зохион байгууллаа.

2019-2020 оны хичээлийн жилийн нээлтийн арга хэмжээг амжилттай зохион байгуулж, сургуулийн дотуур байранд бага ангийн 60, дунд ангийн 41, ахлах ангийн 21 сурагчийг хүлээн авсан. Монголын багш нарын 53 дахь өдрийн баярыг угтан зохион байгуулсан "СЭЛЭНГЭ" бүсийн спортын наадмын шилжин явах цомоор Зүүнбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн хамт олон шагнагдлаа.

Сумын 1 дүгээр цэцэрлэг нь хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 3612 хүүхэд өдөр хамруулахаас 2908 хүүхэд хамрагдаж, биелэлт 80,5 хувьтай, 24 цагийн ажиллагаатай бүлгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 510 хүүхэд хоног хамруулахаас 307 хүүхэд хоног хамруулж төлөвлөгөөний биелэлт 60,1 хувьтай байна.

Сумын эрүүл мэндийн төвд 29 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулаториор 203 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 98, урьдчилан сэргийлэх үзлэгээр 68, дисдансерийн хяналтаар 13, гэрийн идэвхтэй эргэлтээр 11, дуудлагаар 13 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлээ. Хүүхдийн хяналт:Амьсгалын замын өвчнөөр 0-5 насны 2 хүүхдийг хэвтүүлэн эмчилж, ээлжит товлот вакцины хамрагдалт 1 хүртэлх насны хүүхдийг 100 хувь, цусны гемоглобин, тэмбүү илрүүлэх, ХДХВ шинжилгээнд 4 эх, а ртерийн даралт чихрийн шижингийн үзлэгт 25 иргэнийг тус тус хамрууллаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн сургалтыг 2019 оны 08 сарын 26-ны өдөр зохион байгуулж боршур, гарын авлага бэлтгэн 150 ширхэгийг тараан ажилласан. Сургалтанд төсвийн байгууллагын албан хаагчид болон иргэд нийт 150 гаруй иргэд, албан хаагчид хамрагдлаа.

Шаамар сум:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/50 тоот захирамжаар “Орон сууцны тооллого-2019” арга хэмжээг зохион байгуулах чиглэл ирүүлсний дагуу сумын Засаг даргын 2019 оны А/16 тоот захирамжаар орон нутагт “Орон сууцны тооллого”-ыг удирдлага зохион байгуулалтаар хангах сумын түр товчоог 7 хүний бүрэлдэхүүнтэй, тооллогын комиссыг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын төлөвлөгөө, зураглал, маршрутыг батлуулан ажиллаж байна. 2019 оны 09 дүгээр сарын 24-нөөс тоологчийг ажиллуулж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 408 өрх бүртгэхээс 118 өрхийг тоолж мэдээллийн санд баталгаажуулан ажлын гүйцэтгэл 30 хувьтай хэрэгжиж байна. Дулаанхаан тосгоны тоологч 406 өрх бүртгэхээс 78 өрх бүртгэж 20 хувийн гүйцэтгэлтэй байна.

2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Сэлэнгэ аймагт хийгдсэн Улсын үзлэгийн 8 хүний бүрэлдэхүүн ажлын хэсэг тус суманд ажиллаж сумын Засаг даргын Тамгын газрын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт, мэдээллийн технологийн үйлчилгээг нэвтрүүлсэн ажилтай танилцаж, орон нутгийн дэвшилттэй талууд болон хууль тогтоомжийн хэрэгжилт сул, хангалтгүй хэрэгжиж буй зарим асуудлыг яаралтай шийдвэрлэх арга замыг зааж зөвлөн ажиллалаа.

2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын төлөвлөгөөний дагуу малын тарилга, туулгалт, ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулах, урьдчилан сэргийлэх тухай аймгийн Засаг даргын А/154 тоот захирамжийн дагуу сумын Засаг даргын 2019 оны А/54 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулж, ажлын төлөвлөгөөг батлуулан сумын Мал эмнэлгийн үржлийн нэгжүүдээр малын вакцин, тарилга туулгалтын ажлыг гүйцэтгүүлж байна. Тухайлбал: сумын хэмжээнд Дуут хавдар 218 өрхийн 3043 толгой үхэрт, Цусан халдварт 175 өрхийн 6210 толгой үхэрт, ДХХ-ийн вакциныг 6 өрхийн 4400 толгой бог малд давтан тарьсан, Гахайн цусан халдварт иж балнад 3 өрхийн 400 толгой гахайд/давтан хийж, колибактериоз 1 өрхийн 150 толгой бодод /давтан/ хийсэн. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 403 өрхийн 1000 нохой, гахайн мялзан 4 өрхийн 400 толгой гахай, боом 185 өрхийн 9600 толгой адуу, үхэрт хийсэн, боомын вакциныг 11 өрхийн 2800 толгой бог мал, адууны томуу 1 өрхийн 40 толгой адуунд харъяа багийн МЭҮН-үүдээр хийлгээд байна. “Вакцин тарилга эхлэхээс өмнө тарих заавар, аргачлалын талаар заавартай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн. Мал празит өвчнөөс урьдчилан сэргийлэх 31 өрхийн Бод-341, бог-10560 толгой малыг хамруулж Цефрин 7.5 хувийн 7 литрийг 21 тн усанд найруулж угааж, 32 литр креолинийг 32 тн усанд найруулж угаалга хийсэн. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийг 200 өрхийн малчин мал бүхий иргэд танилцуулж Засгийн газрын 225-р тогтоолыг танилцуулж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн. Малын өрхийн эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийсэн талаар хяналт хийж 30 малчин, мал бүхий иргэдээр ороход бичилт хийгдээгүй 5 өрх айл байсныг харъяа багийн МЭҮН-н эмчид нь мэдэгдэж бичилтийг бүрэн хийлгүүлсэн.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын захирамж гаргаж, МЭҮН-ийн эмч нарын санхүүжилт хүссэн тарилгын акт, материалыг нэг бүрчлэн нягталж, материалыг аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн. Мөн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг байгальд халгүй аргаар устгах ажлыг зохион байгуулахад шаардлагатай орон нутгийн талхлагдсан бэлчээрийн судалгааг Охиндий багийн “Их буланд” 3 цэгт, Орхоны гүүрийн ард ногооны талбайн орчим 2 цэгт нийт 5 цэгийг сонгон танталт хийхэд дунджаар 41-гээс 60 хүртэлх тооны үлийн цагаан оготно гарснаар “сийрэг” /1 га талбайд байгаа үлийн цагаан оготны эзлэх хувь / төлөвтэй гарсныг судалгаагаар хүргүүлэв.

Хадлангийн талбайтай болох хүсэлт гаргасан Дэлгэрхааны 1-р багийн малчин 5 иргэн, мал бүхий 4 иргэн нийт 9 иргэнд 74 га талбайг хуваарилж, Охиндий 2-р багийн малчин, мал бүхий 6 иргэнд нийт 60 га хадлангийн талбайг хуваарилан олгож, сумын хэмжээнд нийт 155 га талбай олгоод байна. Халдан ихээр бэлдсэн иргэдэд өвсөө зарах бол сумаас гадгаш гаргаж зархгүй байх цаг хүндэрсэн үед сумандаа зарах талаар 5 иргэнтэй тохиролцсон.

Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Намрын ногоон өдрүүд 2019” үзэсгэлэн худалдаанд оролцох иргэдийг бүртгэж, холбогдох газарт хүргүүлсэн бөгөөд үзэсгэлэн худалдаанд тус сумын 22 иргэн, 2 хоршоо оролцож бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж байна.

“Дэлгэрэх хүр” ойн санг гэрээгээр эзэмшигч иргэдийн нөхөрлөлийн ойд тохируулах төрлийн огтлолттой 5 га талбайд хяналтын ажлыг Сум дундын ойн ангийн холбогдох мэргэжилтэнтэй хамт явуулж, тусгаарласан талбайн 90 гаруй хувьд огтлолтыг хийж гүйцэтгэсэн байсан ба огтлолт хийсэн талбайгаа дуусгаврын актаар хүлээлгэж өгөхийг сануулж, Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтоос 2828000 төгрөг, жимс жимсгэнээс зөвшөөрлөөс 654500 төгрөгийн орлогыг төрийн санд тушаалгасан.

2019 оны 9-р сард нийгмийн халамжийн тэтгэвэрийн сангаас 56 иргэнд 9683.7 мян.төг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн сангаас 46 иргэнд 3680.0 мян.төг, жирэмсэн эхийн тэтгэмжийн сангаас 24 эхэд 838.1 мян.төг, цалинтай ээж хөтөлбөрийн сангаас 92 эхэд 4652.3 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Нийгмийн даатгалын сангийн 8 сарын тайлан тэнцэлээр 24 ажил олгогч, 230 даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлж, сайн дурын даатгалд шинээр 1 даатгуулагч хамруулж нийт 113 даатгуулагчийн шимтгэлийг сар болон улирлаар төлүүлж, нийгмийн даатгалын тэтгэврийн сангаас олгодог 3 төрлийн тэтгэвэр авагчдын мэдээллийг аймгийн НДХ-т мэдээлж, дараа сарын 1-ний дотор тэтгэврийг орон нутагт санхүүгийн үйл ажиллагаа явуулж буй 2 банкаар олголтыг хийж байна.

Мандал сум:

Тайлант сард Монгол-Оросын хувь нийлүүлсэн УБТЗ-ийн Зүүнхараа өртөөний түүхт 70 жил, Зүүнхараа политехникийн коллеж үүсгэн байгуулагдсаны 10 жил, “Цант-Орхон” ХХК үүсгэн байгуулагдсаны 20 жилийн түүхт ойн баяруудыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг санан дурсах тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх, тэдний үр хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх ажлыг 9-р сарын 10-ний өдөр зохион байгуулж, хэлмэгдэгчдийн үр хүүхдүүдийг хүлээн авч, уулзан тэдний санал хүсэлтийг сонсож, “Бороо гоулд” ХХК-ий дэмжлэгтэйгээр нийт 13 хэлмэгдэгчийн үр хүүхдүүдэд нэг портер түлээний мод, 3 хүнд иж бүрэн таван ханатай гэр өглөө.

Төрийн албан хаагчдын сэтгэлгээг эерэгээр өөрчлөн хөгжүүлэх замаар хамтын манлайлыг бий болгох, баг хамт олонд эерэг уур амьсгал бүрдүүлэх, найрсаг харилцаа бүтээлч сэтгэлгээг бий болгох зорилгоор Хан Голомт төвийн тэргүүн Ц.Азбаярыг урьж, “Төрийн албан хаагчийн нийгмийн манлайлал” сэдэвт 8 цагийн сургалтыг зохион байгуулж, 60 гаруй албан хаагчдыг хамрууллаа.

2019-2020 оны хичээлийн жил эхэлсэнтэй холбогдуулан сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 6-12-р ангиуд, ахлах ангийн 17 бүлгийн сурагчдад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг хүүхэд хамгааллын ажилтан, сэтгэл зүйч нар хамтран зохион байгууллаа.

Нийтийн номын сангийн шинэ уншигчаар 172 хүн бүртгэснээс гэрээр ном олгох карт 7 хүнд олгов. 1854 ирэгсэдэд 2387 ном хэвлэл олгож уншууллаа. Мөн WiFi, интернэт үйлчилгээг уншигчдад хүргэж, шинэ мэдээллээр хангаж сонсдог ном 85 уншигчдад уншууллаа.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 27 кейс ирснээс 21 кейс хаагдаж, бусад кейсүүдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Гэрч хохирогчийг түр хамгаалах байрнытохижилтыг сайжруулах зорилгоор ДЗОУБ-ын

ЗХОНХХ-т хүсэлт тавьснаар 13,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг гаргуулж, хүүхдийн тоглоом, ном гарын авлагаар хангасан.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж онцгой тохиолдлын 1 удаагийн буцалтгүй тусламжид гал түймэрт өртөж гэр оронгүй болсон өрхөд -1, харж хандах үр хүүхэдгүй ганц бие ахмад настанд-1, бүтэн өнчин хүүхдэд-1, ихэр хүүхдийн тэтгэмжид-2 иргэнийг хамруулахаар уламжлав. Байнгын асаргаа шаардлагатай ахмад шинээр-3, сунгалт-3, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр-1, сунгалт-5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд шинээр-1, сунгалт-1, өрх толгойлсон эцэг, эхэд олгох тэтгэмжид-2 нийт 21 иргэний өргөдлийг шийдвэрлэлээ. Шинээр төрсөн 34 хүүхдийг бүртгэж, өрхийн мэдээллийн санд бүртгэв. Тайлант сард өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдахаар шинээр хүсэлт ирүүлсэн 328 өргөдлөөс 278 хүсэлтийг шийдвэрлэж 84,7 хувийн гүйцэтгэлтэй байна. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор жижиг зээлд хамрагдах иргэний бүртгэлийг хүлээн авч, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. 9-р сард өссөн дүнгээр 28 иргэн бүртгэлд хамрагдсан. Мөн жижиг зээлд хамрагдах сонирхолтой 3 иргэнтэй уулзаж ярилцан дэлгэрэнгүй мэдээлэл өгч, нийтийг хамарсан ажлаар 3-р багт Хүүхдийн тоглоомын талбайг бетондож, тоглоом угсрах ажил хийгдлээ.

Улсын аварга шалгаруулах пара хөнгөн атлетикийн тэмцээнд сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн баг тэргүүлээ. Буриад Улсад зохион байгуулагдсан суугаа гар бөмбөгийн “БАЙКАЛ-2019” тэмцээний шатрын төрөлд Б.Анхзаяа тэргүүн байр, цом алтан медаль хүртлээ. Мөн хүүхдийн спортын 6-р их наадмын пара хөнгөн атлетикийн төрөлд F 55-57 бөөрөнцөг шидэлтэнд Б.Дашхишиг дэд байр эзэлж мөнгөн медалийн эзэн болсон.

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд 33900 охин төл малыг хамруулдаа. Мөн шинжилгээнд түүврийн аргаар 800 толгой хээлтүүлэгч, 120 хээлтэгч, мал амьтны угаалганд 62114 толгой мал хамрууллаа. Хадлангийн талбай ашиглалтын гэрээг 95 малчин, мал бүхий өрхүүдтэй байгуулан, хадлан тэжээл 7860 тн хадлан, халгайн дарш 15 бэлтгэлээ.

Сумын хэмжээнд үр тарианы хураалт 50 га талбайгаас 60 тонн, төмс 260 га талбайгаас 2860 тонн ургац хурааж 50 хувьтай, хүнсний ногоо 272 га талбайгаас 5906 тоннын ургац хурааж 70 хувьтай байна.

Төв суурийн газрын хүн амыг төмс, хүнсний ногоогоор үйлдвэрлэгчээс хэрэглэгчийг шууд хангах зорилгоор Улаанбаатар хотын 3 дүүргийн 6 цэгт 58 ногоочин үзэсгэлэн худалдаанд оролцлоо.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголтыг 8 аж ахуйн нэгж, байгууллага, 2 иргэнд 1178,6 м3 хэрэглээ, 456,1 м3 түлээ буюу нийт 1634,74 м3 мод бэлтгэх зөвшөөрөл олгож, 14 аж ахуйн нэгж, байгууллагад 1162м3 хэрэглээний, 246 м3 түлээний нийт 1408 м3 мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олголоо

Сумын Засаг даргын 2019 оны А/173 тоот захирамжаар 11 газарт газрын дуудлага худалдааг цахимаар, танхимаар зохион байгуулж 8 газрыг 11,4 сая төгрөгөөр зарж, газар өмчлүүлэх тухай сумын Засаг даргын захирамжаар нийт 22 иргэнд 4,9 га газар өмчлүүлсэн байна. Мөн газар эзэмшихтэй холбоотой 16 иргэний асуудалыг бүрэн шийдвэрлэсэн байна. Газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлт гаргасан 47 иргэний хүсэлтийг улсын бүртгэлд илгээлээ

Тайлант сард хотын төвийн доторх болон гэр хорооллын гудамжны 43 км хайрган хучилттай замыг засварлаж, сумын шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1, 2, 3, 4, 6-р багуудад 8 км орчим 6 кВ-ын кабель шугам, 0.4 кВ-ын агаарын шугам, 100-400 кВт-ын хүчин чадалтай 16 ширхэг трансформатор, 1 ширхэг хуваарилах байгууламж барих ажлын гүйцэтгэл 60 хувьтай, 3-р баг цэвэрлэх байгууламжийн хойд болон зүүн хэсэгт байрлах цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй 50 гаруй айл өрхүүдийн дунд шинээр 160 кВа чадалтай трансформатор, 6 болон 0,4 кВ-ын агаарын шугам барих ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. Мөн 37 аж ахуйн нэгж, 198 орон сууцны айл өрх, 2172 гэр хорооллын айл өрхийн нийт 2407 энгийн тоолуурыг ухаалаг 2 тарифт тоолуураар

шинэчиллээ. Ингэснээр нийт өрхийн 64,5 хувь нь ухаалаг тоолуурын системд бүрэн шилжлээ.

Баянгол сум

Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2020 онд сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг боловсруулан сумын ИТХ-д өргөн барилаа.

Тайлант сард аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 15 албан 09 дүгээр сарын 11-ний өдөр ажиллаж, 2019 оны 04 дүгээр сард хийгдсэн төлөвлөгөөт хяналт, шалгалтын гүйцэтгэлийг шалгалаа.

Сумын Засаг даргын 2019 оны А/164 тоот Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай захирамжийг гарган, хэрэгжилтийг хангуулах ажлын хэсгийг томилон ажиллуулсан бөгөөд эрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй “Хандлагаа өөрчилье” багц аяны хүрээнд “Хоггүй цэвэрхэн Монгол” аян, аяныг өрнүүлэх тухай аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 1/642 тоотын дагуу аяныг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган 2019.10.01-2020.06.01-ний хооронд зохион байгуулан ажиллаж байна. Аяны хүрээнд Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчид Хараа гол дагуу 2,5 км орчим газрын хог хаягдлыг цэвэрлэж 2 портер хог хаягдлыг төв хогийн цэгт тээвэрлэн булшилсан.

Тус сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Соноор трейд” ХХК нь Гонир 3 дугаар багийн Иргэдийн нийтийн хурлаас гаргасан саналын дагуу багийн 1 дүгээр хэсэгт гаргасан гүний худаг, гол горхи, булаг шандын эх үүсвэрийг хамгаалах зорилгоор 4 дүгээр хэсэгт байрлах Дожоо вангийн булгийн 250 метр газрыг хашиж хамгаалах ажлыг тус тус гүйцэтгэн, хүлээн авах ажлыг зохион байгууллаа. Мөн 400 хүний суудалтай соёлын төвийн барилгын шав тавих ёслолын арга хэмжээг 09 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж, соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн суралцагчдын тоглолтыг толилууллаа. Арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл 120 гаруй хүн оролцлоо.

Сумын Залуучуудын холбоо, эмэгтэйчүүдийн холбоо хамтран “Өөрчлөлтийг өөрөөсөө” урлаг, спорт, сургалтын нэгдсэн арга хэмжээг зохион явуулж, 160 гаруй залуучууд оролцож, караоке тэмцээн зохион явуулж 5 багийн 25 авьяастан оролцож 95 иргэн үзэж сонирхлоо.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан ИТХ, Баянгол сумаас хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийн ач зээ, төрөл садан, ЕБС-ийн ахлах ангийн суралцагчид, ахмад багш нартай хамтран “Хэлмэгдэл ба цагаатгал” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд “Хэлмэгдүүлэлт миний нүдээр” гар зургийн уралдаан, “Хэлмэгдэл ба цагаатгал” сэдвээр лекц тавьж, харилцан ярилцлагыг зохион байгуулж, ту сумын харъяат 71 хэлмэгдэгсдийн материалаар үзэсгэлэн гаргасан.

“Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК-ий нийгмийн хариуцлагын хүрээнд 86.310.750 төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Түвшин Тулга Констракшн” хийсэн сургуулийн хичээлийн байр, дотуур байр, хүүхдийн цайны газрын гадна хананд дулаалга фасад, дээврийн ажлыг гүйцэтгэж, тав тухтай, тохилог, дулаан орчинд суралцах боломжийг бүрдүүлсэн.

2019-2020 оны хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, Ази тивийн аварга сурагч Н.Орхонцэцэг, Д.Батзаяа нарыг биеийн тамирын хослолоор, дасгалжуулагч багш Б.Лхагвасүрэн, Н.Батболд нарыг зөөврийн компьютероор урамшууллаа. Энэ үеэр ахмад багш Д.Төртүвшингийн “Цаасан хайчилбарын хөргүүд” номын нээлт номын дээжийг гардуулан өглөө.

Австрали улсын Griffith их сургуулийн доктор, профессор Hamish McLean, багш Duncan McConnell, Австрали улсын бага сургуулийн англи хэлний багш Judith McLean, Канад улсын Гал унтраах ангийн төлөөлөгч Darrell Red, Joe Acker нар 2019

оны 9 дүгээр сарын 03-ны өдөр манай сургуульд зочилон сургуультай танилцаж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо.

Дэлхийн багш нарын баярын 25 жил, Монголын багш нарын 53 жилийн ойн баярыг угтан зохион байгуулсан “Багш -2019” Хараа бүсийн багш нарын уламжлалт спортын тэмцээн 09 дүгээр сарын 20,21-ний өдрүүдэд Мандал сумын Түнхэл тосгоны ЕБС дээр амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд сургуулиа төлөөлөн 21 багш 5 төрөлд оролцож “Шагай харваа”-ны төрөлд алтан медаль, “Сагсан бөмбөг”-ийн төрөлд эрэгтэй баг тамирчид Алтан медаль, “Гар бөмбөг”-ийн төрөлд эрэгтэй баг тамирчид мөнгөн медаль, эмэгтэй баг тамирчид хүрэл медалийг тус тус хүртэж багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ.

Хүүхдийн Спортын VI наадамд тус сургуулийн 22 тамирчин амжилттай оролцсноос “Гар бөмбөг”-ийн эрэгтэй төрөлд 10б ангийн суралцагч Г.Төмөр “Мөнгөн медаль”, эмэгтэй төрөлд 10б ангийн суралцагч Г.Уянга,С.Уран-Эрдэнэ нар хүрэл медаль”, “Сагсан бөмбөг”-ийн 3:3 төрөлд 12б ангийн суралцагч Б.Мөрөн мөнгөн медаль тус тус хүртсэн байна. Монголын Үндэсний Харваачдын холбооноос зохион явуулсан 2019 оны Өсвөрийн Отго харваанд 9б ангийн суралцагч Г.Балжинням тэргүүн байр, Э.Мишээл 3-р байр, Мэргэн зөв клубын 2019 оны Үндэсний сурын хаалтын Отго харваанд 9б ангийн суралцагч Э.Мишээл тэргүүн байр, Б.Ариунсанаа 3-р байрыг тус тус эзэлсэн амжилтыг үзүүлээд байна.

Аймгийн БСУГ-ын түүхт 60 жилийн ойн хүрээнд Партизаны талбайд зохион байгуулагдсан байгууллага сурталчлах үзэсгэлэнд амжилттай оролцсон. Орон нутаг судлах танхимаас сумын соёлын өв тээгч Д.Төртөвшингийн “Хөрөг” уран хайчилбарын 45 бүтээлээр үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэнг 250 хүн үзлээ.

Сумын цэцэрлэг түүхт 50 жилийн ойг угтаж төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн цэцэрлэгийн гадна дотно талд хүүхдийг сурч хөгжих ая тухтай орчныг бүрдүүлж тохижилтын ажлууд хийгдэж байна. Б.Эрдэнэтуяа багштай дунд А бүлэг эцэг эхийн тусламж дэмжлэгтэйгээр 4.270.000 төгрөгний “Тохилог тухтай хүлээлгийн танхим” төсөл хэрэгжүүлж дуусган цэцэрлэгийн захиргаанд хүлээлгэн өгсөн. Туслах багш Б.Болормаагийн санаачилсан 3000.000 төгрөгний “Бидний гал тогоо” төслийг “Мөнгөн бат трейд” ХХК-ийн захирал Д.Мөнгөнчимэг ивээн тэтгэж хэрэгжүүлж дуусгалаа. “Ёс заншлын өргөө” төслийг Т.Төрмөнх ивээн тэтгэж 14.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийж Цомцог ХХК хийж гүйцэтгэн цэцэрлэгийн захиргаанд хүлээлгэн өгч, “Бороо гоулд” ХХК -аас 8 хүүхдэд хичээлийн хэрэгслээр бэлэг гардууллаа.

Сумын Жрүүл мэндийн төв тайлант сард амбулаториор нийт 586 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 26 иргэнийг онош тодруулахаар илгээсэн. Стационарт 16 хүнийг хэвтүүлэн эмчилсэн. ЭМТ-ийн эмийн сан нь ЭМД-ын хөнгөлттэй цахим эмийн жороор 84 иргэнд 1411,680 төгрөг, энгийн эмийн жороор 841 иргэнд 3845,4 төгрөгийн эм борлуулан үйлчилсэн. Сумын ЭМТ-ийн барилга 1968 онд анх баригдаж ашиглалтад орж, анхан шатны эмнэлгийн үйл ажиллагаа явуулах өрөө тасалгааны хүртээмж муутай байдгийг харгалзан тус сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Тод Ундарга” ХХК, сумын удирдлагуудын зүгээс нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан эрүүл мэндийн төвийн барилгад өргөтгөлийн хэсгийг бариулах санал тавьснаар яаралтай тусламжийн нэгжийн өртгөтгөлийн шинэ барилга баригдаж дууссан улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. Шинэ баригдсан яаралтай тусламжий хэсэгт зүрхний цахилгаан бичлэгийн аппарат-1, билметр-1, зөөврийн рентген-1, сорлуулах аппарат-1, дуслын автомат-1, тарианы автомат шахуурга-2, монитор-1, нярайн жин-1, кварцын гэрэл-3, дуслын штатив-4, тэргэнцэр-2, кушетка-3 тус тус ирсэн байна.

2019 оны 9 сарын байдлаар артерийн гипертензи, чихрийн шижин өвчний илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 1462 иргэнийг 100 хувь, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 390 иргэн, хөх умайн хавдар эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 287 эмэгтэй хамрагдахаас 97 хүн хамрагдаж, эрт илрүүлэг үзлэг 33 хувьтай байна.

ЕБС-ын бага, дунд ангийн 8 бүлгийн 251 хүүхдийг “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд аян”-ны хүрээнд амны хөндийн урьдчилэн сэргийлэх үзлэгт хамруулахад

хүүхдүүдийн 80 хувь нь шүдний өвчлөлтэй гарсан бөгөөд багш сурагчдад амаа зөв угаах талаар зөвлөгөө өгч, эмчлэн эрүүлжүүлэхийн ач холбогдлын талаар сурталчилсан.

Энэ сард газар өмчлөлийн 26 эзэмшихээр 19 иргэн аж нэгжээс өргөдөл хүлээн авч сумын Засаг даргын захирамжаар 20 иргэнд 0,14 га газрыг өмчлүүлж, 1 иргэнд 371,7 м² газрыг аж ахуйн зориулалтаар 312228 төгрөгөөр төлбөртэйгээр өмчлүүллээ. Мөн 3 иргэнд өвөлжөөний зориулалтаар 2,28 га газрыг, газар эзэмших эрх шилжүүлэхээр 3 иргэн 1 ААН-ийн 2,56 га газрын эрхийг тус тус шилжүүлсэн.

Баян багийн Нарангийн ам гэх газарт бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох зорилгоор үйл ажиллагаа явуулсан Ч.Энхжин ахлагчтай Баян Угалзын хөндий хоршоо нь Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор баталсан журмын 3.1.4 дах хэсэгт заасан “Нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтанд орсон бичил уурхай эрхлэгч хуулийн этгээд нь ашигт малтмал олборлохдоо 3500 см³ хүртлэх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос ирүүгүй механизмыг ашиглах” гэсэн заалтыг зөрчиж 1.500.000 төгрөгийн, Гонир багийн иргэн Ц.Нямдорж нь хадлангийн талбайд мал бэлчээсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 7.7 зүйлийн 2 дах заалтын дагуу 150,000 төгрөгийн торгуулийг тус тус ногдуулж бүрэн барагдуулсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч “Тод Ундарга” ХХК нь техникийн нөхөн сэргээлт 19 га, биологийн нөхөн сэргээлт 12 га, “Тайхаржин майнинг” ХХК нь техникийн нөхөн сэргээлт 10,5 га, биологийн нөхөн сэргээлт 7,5 га, бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч “Баян Өгөөж Хараа” нөхөрлөл техникийн нөхөн сэргээлт 1 га, Хараа нутгийн буян нөхөрлөл техникийн нөхөн сэргээлт 2 га нийт 32,5 га талбайд техникийн, 19,5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн.

2019-2020 онд 421 малчин, 364 мал бүхий иргэдийн 138797 толгой мал хонин толгойд шилжүүлснээр 262223 толгой мал өвөлжихөөр бэлтгэл ажлыг хангуулж байна. Өвөлжилтөнд зориулж сумын хэмжээнд 11800 тн байгалийн хадлан, сумын нөөцөд 160 тн өвс, 45 тн тэжээл бэлтгэх төлөвлөгөөтэйгөөс бороо хожуу орсонтой холбогдуулан хадлангийн гарц муу, нийт талбайн 28-30 хувь нь хадах боломжгүй байна. 2019 оны 09 сарын 23-ны өдрийн байдлаар хадлан бэлтгэл 56 хувьтай байна. Монгол улсын Засгийн газрын 225 тоот тогтоолын хавсралтад заасан мал амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд МЭҮН-үүд 2019 оны төлөвлөгөөт тарилгад 44000 бод, 104600 бог, 2400 амьтан, нийт 151000 мал амьтан хамруулаад байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд мал угаалгын ажилд төлөвлөгөөт 114000 толгой мал хамруулхаас 08 сарын 9-өөс эхэлсэн мал угаалгын ажилд шумбуулж 88151 толгой бог мал, шүршиж 29506 толгой бог, 12914 толгой бод, 97 толгой гахай, нийт 122638 толгой мал амьтан угаагаад байна

Суманд үйл ажиллагаа явуулдаг МЭҮН-үүд 203 өвөлжөөний 16769 м² талбайд ариутгал хийсэн байна.

Үр тариа хураалт 16 хувьтай, 2489 га талбайг ангилан хурааж, 746 га талбайгаас цайруулан 1046 тн улаан буудай үтрэмд буугаад байна. Төмс хүнсний ногооны хураалт 65 хувьтай 70 га талбайгаас 769 тн төмс, 46 га талбайгаас 557 тн хүнсний ногоо хураан авч, 7 иргэн Улаанбаатар хотноо Ялалтын талбайд үзэсгэлэн худалдаагаар дамжуулан борлуулалт хийж байна.

Сайхан сум

"Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгаа" аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ДЗОУБ-ын дэмжлэгтэйгээр "Нийгмийн манлайлал" сургалтыг төрийн албан хаагчдын төлөөллийг оролцуулан зохион байгууллаа. Сургалтыг Монголын илтгэгчдийн холбооны ерөнхийлөгч, "Хан голомт" төвийн захирал Ц.Азбаяр багш удирдан явуулж, нийт 110 төрийн албан хаагч, төрийн байгууллагын дарга, эрхлэгч нар хамрагдаж, хувь хүний хөгжил, байгууллага хамт олны хөгжлийн талаарх сонирхолтой хичээлүүдээс суралцлаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны 08-р сарын 09-ний өдрийн 07 албан даалгавар, Сумын Засаг даргын “Ургацын комисс байгуулах тухай” А/165 тоот захирамж, Хадлангийн талбай ашиглалтыг зохцуулах тухай А/166 тоот захирамжийн дагуу байгаль цаг уурын нөхцөл байдлаас үүдэн намрын ургац хураалт, хадлан тэжээлийн бэлтгэлийг хангах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллаж байна. Энэ онд сумын хэмжээгээр 28 аж ахуйн нэгж, 15 иргэн нийт 15649.3 га-д тариалалт хийснээс үр тарианы талбайд улаан буудай 11891 га, тэжээлийн ургамал 2222 га, рапс 1398.3 га, гурвалжин будаа 138 га, төмс хүнсний ногооны талбайд 5 аж ахуйн нэгж, 65 иргэн нийт 488 га буюу төмс 250 га, хүнсний ногоо 238.35 га, овьёос 15 га, царгас 12 га тариалсан. Улаан буудай 7200 га-гаас 9267 тонн буюу 12.8 цн, рапс 810 га-аас 750 тонн ба 9.2 цн, төмс 210 га-аас 2625 тонн, хүнсний ногоо 177,4 га-аас 2838,4 тонн хураан авч, байгалийн хадлан 4580 тонн, ногоон тэжээл 3500 тонныг бэлтгэсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын дагуу Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газартай иргэдийн өвөлжилтийн бэлтгэл, түлээ түлшний хэрэгцээг хангах арга хэмжээ авч, сумын харъяат 119 иргэнд, Орхон сумын харъяат 210 иргэнд нийт 230 м3 түлээний модны гарал үүслийн гэрчилгээнд бичилт хийж, хяналт тавин ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих СЭАСХСЗДТГ-201912001 тоот “Шинэдэлгэр” ХХК-ий хашаанаас Сум дундын эмнэлэг хүрэх 100 метр бетонон авто замын ажлын тендерт “Сүж ундрага” ХХК шалгарсан, ажлын явц 50 хувьтай, “Номгон тосгоны нийтийн халуун усны газар” байгуулах ажлын тендерт “Сайхан төгөл” ХХК шалгаран, ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 9 дүгээр сард 1 удаагийн захирамжаар 54 иргэн нийт 64378 м2 газрыг үнэ төлбөргүй өмчлүүлж, өмчлөлийн газраа эрх шилжүүлсэн 12 иргэн, газар эзэмшлийн гэрчилгээгээ банк санхүүгийн байгууллагад барьцаалж, барьцаанд бүртгүүлсэн 1 иргэн, чөлөөлсөн байхгүй мөн газрын харилцаатай холбоотой тодорхойлолт 15 иргэнд олгосон.

Суманд үйл ажиллагаа явуулж буй “Мөнх ариун Сэлэнгэ” ХХК-тай хамтран 2 сургууль, 3 цэцэрлэг, худалдаа үйлчилгээний 8 байгууллагад ариутгал халдавргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг шалган зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Үдийн цай хөтөлбөрт сумын хэмжээнд 876 хүүхэд хамрагдаж байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12-р сарын. 03-ны өдрийн “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хангах, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилгоор сумын бүх аж ахуйн нэгж, байгууллагуудад эцэг эхийн зөвлөлийг байгуулан ажиллуулж, эхэлсэн Энэхүү эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд ажлын чиглэл өгөх зорилгоор чадавхжуулах сургалтыг хүүхэд хамгааллын “Үжин” төвийн үүсгэн байгуулагч, хамтарсан багийн үндэсний сургагч багш Б.Ундраа заан явуулж, гэр бүл, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргийг бууруулах нь дан ганц цагдаа, төрийн захиргааны байгууллагын ажил биш бөгөөд нийгмийн олон талт үйл ажиллагаагаар дамжуулан байгууллага, иргэн бүр хамтран оролцож, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, нөхөн сэргээх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахын чухлыг онцолсон жишээ баримт, үндэслэл нотолгоон дээр суурилсан сургалт зөвлөгөөг хүргэлээ.

Тээврийн Цагдаагийн газраас Улсын хэмжээнд зохион байгуулж "Яараад яахав дээ" нэгдсэн арга хэмжээний хүрээнд сумын ЗДТГ, Сум дундын цагдаагийн хэлтэс, ЕБС сургууль хамтран ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд шторкны уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд ахлах ангийн 10 ангийн хамт олон бүтээлээ ирүүлснээс 1-р байрыг Ж.Эрдэнэтуяа багштай 11-а анги, 2-р байрыг Б.Оюунсүрэн багштай 9-г анги, 3-р байрыг Ш.Ариунаа багштай 10-а анги тус тус эзэлсэн байна.

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу 09 дүгээр сарын 02-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн хүүхдүүдэд Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай, Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай мэдээлэл хүргэж гарын авлага, тараах материал бэлтгэж хууль сурталчлах арга хэмжээ авч, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш ажилчдад гарын авлага тараах материал хүргүүлж, завсарлагааны үеэр болон өдөр, орой хичээл тарах үед “**School Police**” эцэг эхийн хяналтын эргүүлийг сайтар ажиллуулж, замын хөдөлгөөнд соёлтой оролцох уриалгыг гарган хэрэгжүүлж байна.

Хичээлийн шинэ жил эхэлж, сумын хэмжээнд Ерөнхий боловсролын 2 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 4 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. 2019-2020 оны хичээлийн жилд Сайхан сумын ЕБС-д 1623, Номгон ЕБС-д 310 сураг, СӨБ-ын 28 бүлэгт 2-6 насны 818 хүүхэд сурч, хамран сургалт 98 хувьтай байна.

Сумын соёлын ордонд сантехник, гадна пасадны засварын ажил хийгдэж гүйцэтгэлийн явц 98 хувьтай байна. Дотор сантехникийн ажил бүрэн дуусч, гаднах буюу газар доорх шугамын ажил хийгдэж байна. Дотоод анги танхим өрөө тасалгааны засвар үйлчилгээ хийгдэж байна.

Сумын залуусын нийгмийн идэвх оролцоог сайжруулах, залуучууд нийгэмд, шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэх боломжийг бий болгох, төрөөс залуучуудын чиглэлээр баримталж буй бодлого шийдвэрийг танилцуулах зорилгоор Залуучуудын чуулганыг ДЗОУБ-тай хамтран зохион байгуулж, сумын 350 залуусыг хамрууллаа. Чуулганд аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог оролцож, мэндчилгээ дэвшүүлсэн.

Сант сум

Ургац хураалтын явцын мэдээгээр үр тариа 260 га талбайд ангилалт хийгдэж 15,3 хувьтай, төмс 180 га талбайгаас 1800 тонн буюу 69,2 хувьтай, хүнсний ногоо 56,5 га талбайгаас 550 тонн ургац хурааж, 66,8 хувьтай явагдаж байна.

Хадлан бэлтгэлийн ажлын явц 46 хувьтай буюу 3210 тонн байгалийн хадлан бэлтгээд байна.

Аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу малчин, мал бүхий өрхийн адуунаас бусад төл малыг тарилганд хамруулах ажлыг зохион байгуулж байгаа ба одоогийн байдлаар Ивэн багийн 18000 толгой төл малд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг тарьж дуусгасан 2-р багийн 8490 толгой төл малын 80 хувийг хамруулаад байна. Мөн Мал эмнэлгийн Ерөнхий газрын 01 тоот удирдамжийн дагуу халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор улирал тутам малын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, нийт 387 өрхийн адуу 4463, үхэр 1255, хонь 32958, ямаа 23520 толгой мал, 10 өрхийн 163 гахайг хамруулсан. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд нийт 42832 толгой бог ванндаж, 428 бод, 14598 толгой бог шүршиж угаасан. Эндопаразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 86 өрхийн 24819 толгой бог, 50 өрхийн 78 нохойнд туулгалт олгосон. Гахайтай 10 өрхийн 23 гахайн байрыг экоцитын уусмалаар шүршиж ариутгаж халдваргүйжүүллээ.

Үндэсний боловсруулах үйлдвэрт хонины ноос бэлтгэн тушаасан малчин, мал бүхий иргэнд мөнгөн урамшуулал олгох журмын дагуу 2019 онд дотоодын үйлдвэрүүдэд хонины ноос тушаасан 71 өрхийн 16 тонн ноосонд мөнгөн урамшуулал олгуулахаар материалыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлсэн.

Аймгийн “Бэлчээр ашиглалтын холбоо” ТББ-аас сумын малчдын бүлгүүдэд бэлчээр ашиглалт, хамгаалал, нөхөн сэргээлт сэдвээр сургалт зохион байгуулж Хушаат 2-р багийн 13 малчин өрх хамрагдсан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд давхардсан тоогоор 385 иргэнд 3288м.куб түлээ, хэрэглээний зориулалтаар 74 иргэнд 378 м.куб модны эрхийн бичиг олгож 10365000 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна. Сумын хэмжээнд иргэдийн түлшний хангамж 95 хувьтай хангагдсан.

Тайлант сард газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах 3, газар эзэмших эрхийг шилжүүлэх 1 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, өвөлжөөний доорхи зориулалтар 5 иргэнд 2.5 га газар, худалдаа үйлчилгээний чиглэлээр газар эзэмших эрхийн дуудлага худалдаанд ялагчаар тодорсон 1 иргэнд 300м.кв газрыг эзэмшүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн байна.

2019 оны байшин орон сууцны тооллогын ажлын хүрээнд сумын Засаг даргын 2019 оны А/27 тоот захирамжаар сум, багийн түр товчоог байгуулан хариуцлагатай жижүүр томилон ажиллаж байна. Сумын хэмжээнд нийт 736 өрх тооллогод хамрагдахаас 34 өрх буюу 4,6 хувийг тооллогод хамруулаад байна.

Тайлант сард урьдчилан сургийлэх үзлэг 132, гэрийн идэвхитэй эргэлт 315, идэвхитэй хяналт 76, амбулаторын үзлэг 59 хийгдэж амьсгалын замын өвчлөл 9 бүртгэгдсэн.

Сумын ЕБС нь 2019-2020 оны хичээлийн жилд нийт 35 багш ажилчид ажиллаж, 1-5 дугаар ангийн 145 сурагч, 6-11 дүгээр ангийн 150 сурагч, нийт 295 сурагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. 1-р ангид 32 сурагч элсэн орж хамран сургалт 86,4 %-тай байна.

Сумын СӨБ-ын байгууллагын үндсэн бүлгийн сургалтад 119 хүүхэд, хувилбарт сургалтанд 14 хүүхэд хамрагдаж нийт хамран сургалт 73 хувьтай байна.

Сумын Соёлын төв, ЕБС хамтран “Соёл-Урлаг-Түүх” 10 хоногийн аяныг Монгол Улсад атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж, ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын дунд явган аялалын тэмцээн, “Атарчдын бахархал” зурагт танилцуулга, 1-5-р ангийн сурагчдын дунд “Атар газар” гэрэл зургийн уралдаанийг явууллаа.

Орхонтуул сум

Сумын Засаг даргын Тамгын газраас Төрийн албан хаагчийн сургалт, солилцоо сумын хөтөлбөр, Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа сумын хөтөлбөрүүдийн хүрээнд “Төрийн албан хаагчдын нэг өдөр” арга хэмжээг 9 дүгээр сарын 13-ны өдөр Рашаант амралтын газарт зохион байгуулж 8 10 байгууллагын 100 гаруй төрийн албан хаагчид оролцлоо.

Сумын Засаг даргын Зөвлөл тайлант сард 2 удаа хэлэлцэж иргэдээс ирүүлсэн өргөдлүүд болон цаг үеийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа. Тайлант сард иргэдээс нийт 8 өргөдөл хүсэлт ирүүлсэн байна. үүнээс ажил хүссэн болон ажил өөрчлөн томилогдох тухай-7, өвөлжөө бэлчээрийн газрын маргаан шийдвэрлүүлэх-1 ирсэнийн шийдвэрлэж хариуг албан тоотоор хүргүүллээ. Мөн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн явц үр дүнг төсвийн байгууллага, мэргэжилтэн бүрээр сонсож, 2020 оны үндсэн чиглэлийн төслийн саналыг авч боловсруулан сумын ИТХ-н ажлын албанд хуулийн хугацаанд хүргүүлэхээр бэлтгэж байна. Шинэ төрсөн хүүхэд, эхчүүдэд хүндэтгэл үзүүлэх журмын дагуу ихэр хүүхэд төрүүлсэн Шар-Ус 1-р багийн иргэн В.Урантуяад 500,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг Засаг даргын нөөц хөрөнгөөр олгохоор шийдвэрлэлээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Архи үгүй амьдрал аз жаргалтай” аяныг сумын Засаг даргын А/101 тоот захирамжаар зохион байгуулж, аяны хүрээнд суманд үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд хяналт шалгалт хийх болон мэдээлэл сурталчилгааны ажлуудыг явууллаа.

Энэ сард шинээр төрөлт-5 бүртгэгдсэн байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-ыг тогтмолжуулан шинэ төрсөн 5 хүүхдэд хүндэтгэл үзүүллээ.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч даатгуулагчдаас 9 сарын 24-ний байдлаар 18621.6 мянган төгрөгийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 9 даатгуулагчаас 293.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг хамруулан шинээр малчин -2, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн-1, ххэрхлэгч-1 иргэнийг тус тус хамруулан

даатгуулагчдаас 2353.2 мянган төгрөгийн орлого оруулж, тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон. “Даатгуулагч танд урьдчилан зөвлөө- тусалъя” аяны хүрээнд 2019-2020 онд тэтгэвэр тогтоолгох иргэдийн судалгааг гарган 10 даатгуулагчдад зөвлөмжийн хуудас өгч зөвөлгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Сумын хэмжээнд улаанбуудай 9889 га талбайд тариалснаас 2690 га талбайгаас 3198 тн ургац хурааж ургац хураалт 27,2%-тай, төмс, хүнсний ногоо хураалт бүрэн дуусч, төмс 25 га талбайгаас 150 тонн, хүнсний ногоо 32,1 га талбайгаас 184,8 тонныг хураан авсан мэдээтэй байна.

Сумын хэмжээнд мал амьтныг халдварт, халдварт бус болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, сүргийн эрүүл мэндийн үзлэг, угаалга, туулгалтын ажил 80%-тай явагдаж байна. Үүнд: Сумын хэмжээнд Боом- 23256 бод, бог-27333, Галзуу-1950 үхэр, нохой-650, Дуут-7757 бод, Томуу-200 адуу, Цусан халдварт-3100 үхэр, ДХХ-9896 бог, Шөвөг яр-26999 төл, Гахайн мялзан-398, Сахуу-1100, Гахайн цусан халдварт-492, гахайд тус тус хийгдэж 2019 оны Хавар, Зуны төлөвлөгөөт вакцинжуулалт 100% хийгдсэн. Мөн мал угаалга-15000 бог болон эрүүл мэндийн үзлэгт-122834 давхардсан тоогоор, мал амьтан хамрагдсан, бруцеллэз-3300 тугал, 29800 хурга, ишиг-31400 вакцинжуулалт хамрагдсан.

Сумын орон нутгийн хөгжлийн сангаас 11 ажлыг хийхээр 134,3 сая төгрөгийн санхүүжилт батлагдснаас одоо байдлаар 78,5 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, нийт ажлын явц 70 хувьтай байна.

Сүхбаатар сум

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголын нутгийн удирдлагын байгууллагын холбоо хамтран багийн Засаг дарга нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх иргэдэд төрийн үйлчилгээг чанартай хүргэх арга барилыг эзэмшүүлэх чиглэлээр “Манлайлал ур чадвар” сэдэвт сургалтад багийн Засаг дарга нарыг хамрууллаа.

Улсын хэмжээнд зохион байгуулагдах байшин орон сууцны тооллогыг зохион байгуулах сумын ажлын хэсгийг томилж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Сумын ИТХ-ын ээлжит 2 дугаар хуралдааны бэлтгэлийг хангаж, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2019 оны биелэлт, 2020 оны үндсэн чиглэлийн саналыг боловсруулан сумын ИТХ-д өргөн барьсан.

Сумын Засаг даргын орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахтай холбогдуулан ЕБС, цэцэрлэгүүдэд хяналт шалгалт хийлээ.

2019-2020 он хичээлийн жилд сумын ЕБС-ийн 1-р ангид 545 хүүхэд шинээр элсэн орсон. СӨБ-ийн байгууллагуудад нийт хамрагдвал зохих хүүхдийн 95,4 хувь нь хамрагдсан.

Тайлант сард сумын 44 өрхөд гэрээр айлчлах гэр бүлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тухайн өрхүүдээс 28 гэр бүлд хүнсний эрхийн бичиг олгож, 8 гэр бүлийн 6 иргэнийг ажлын байранд зуучилж, 44 өрхийн иргэдийг түр ажлын байраар 2 удаа хангаж, 6 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулан, 32 иргэнд сургалт сурталчилгаа хийсэн. Мөн хөтөлбөрийн хүрээнд дээрх өрхийн 143 хүүхэд байгаагаас ДЗОУБ-ийн ХИТХ-г хамрагддаг 25 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 7 хүүхэд байна.

Биеийн тамир, спортын тухай хууль, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх, Ахмадуудын дунд нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцох идэвхийг өрнүүлэх, нөхөрсөн баг, хамт олныг бүрдүүлэх зорилгоор Ахмадын 5 төрөлт ширээний теннис, шатар, дардас, хөзөр, софт волейбол зэрэг тэмцээнийг 2019 оны 09 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тэмцээнд 8 багийн давхардсан тоогоор нийт 120 гаруй ахмад оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тэмцээний нийлбэр дүнгээр 1-р байрт Орхон 6-р баг, 2-р байрт Буурхээр 8-р баг, 3-р байрт Боргүвээ 5-р багийн ахмадууд шалгарлаа.

Сумын хэмжээнд намрын ургац хураалтын ажил 80 хувьтай явагдаж байна. Одоогийн байдлаар 67 га-аас 778 тонн төмс, 34,14 га-аас 338,75 тонн хүнсний ногоо хураан аваад байна. Аймгийн ХХААГ-аас Бага оврын трактор гэрээгээр авсан 47 иргэнд эргэн төлөлтөө хийх мэдэгдлийг өгөөд байна.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Алтан намар” үзэсгэлэн худалдаанд төмс, хүнсний ногоо тариалан эрхэлэгч 6 иргэн оролцож, “Талбайн түүхийн дэвтэр”-ийг үндэслэж гарал үүслийн гэрчилгээ олголоо.

2019-2020 онд сумын 8 багийн малчин болон мал бүхий 366 өрхийннийт 23043 мянган толгой мал үүнээс 2410 мянган толгой адуу, 6154 мянган толгой үхэр, 6739 мянган толгой хонь, 7740 мянган толгой ямаа өвөлжиж хаваржих урьдчилсан төлөвтэй байна.

Сумын малчид мал бүхий иргэдийн мал сүрэгт 2019-2020 онд өвөлжиж, хаваржихад байгалийн хадлан 3037 тонн, үйлдвэрийн тэжээл 250 тонн, гар тэжээл 50,0 тонн давс хужир шүү 88,0 тонн хэрэгцээтэй байгаа ба хэрэгцээт хадланг Шаамар, Алтанбулаг, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын нутаг дэвсгэрээс бэлтгэж байна. Одоогийн байдалаар 854 тонн байгалийн хадлан, давс хужир шүү 10 тонн бэлтгэсэн нь өвөлжилт, хаваржилтийн бэлтгэлийн хангалт 30 хувьтай явагдаж байна

Хушаат сум:

Байшин орон сууцны 2019 оны тооллогын бэлтгэл ажлыг ханган сумын тооллогын түр товчооны гишүүд, сумын ЗДТГ-ын ажиллагсадын дунд тооллогын зохион байгуулалт, үйл ажиллагаа, явцын мэдээлийн талаар сургалтыг зохион байгуулаад байна.

Сумын Ерөнхий боловсролын сургуульд 288 суралцагч суралцаж байгаа бөгөөд улсын төсвийн төсвийн 600,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засварын ажил хийгдэж байгаа бөгөөд 2019 оны 10-р сарын 01-ний байдлаар 90 гаруй хувьтай байна. Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс орон нутгийн боломжийг ашиглан сумын ахуйн үйлчилгээ, соёлын төвд хичээлийг орж, сургалтын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна.

Сумын Цэцэрлэгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөгөөр 2100 хүүхэд хүлээн авахаас 1416 хүүхэд авч, ирц 67.5 хувьтай байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын ЭМТ хамтран цэцэрлэгийн нийт хүүхдүүдийг нэгдсэн байдлаар 89 хүүхдийг шинжилгээнд хамруулж эмчилгээ шаардлагатай хүүхдийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч, дахин шинжилгээнд хамруулах талаар эцэг эх, асран хамгаалагчид зөвлөж, багш ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.

Улсын бүртгэлийн тухай, Иргэний бүртгэлийн тухай хууль бусад холбогдох хууль журмын хүрээнд нотлох баримтуудыг үндэслэн дараахь бүртгэлүүдийг хийлээ. Төрөлт 1, шилжин ирсний 6, өөр аймаг хотоос, баг хооронд 4, нас барсны 1, биеийн давхцахгүй өгөгдлийн 4, газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 10, иргэний үнэмлэх олголтын 8, нийт 30 бүртгэл хийж 2 гэрчилгээг бичиж олгов.

Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудыг сурталчлах арга хэмжээ авч, НДШ-д 5 байгууллага, 29 аж ахуйн нэгжийн 257141.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 134 хүний 42531.1 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 132 хүний 6898.2 мянган төгрөгийн хураамжийг тус тус дансанд оруулсан.

Сумын хэмжээнд 2019.09.24-ний байдлаар үр тарианы ангилан хадалт 2092 га, рапс ангилан хадалт 880 га, гурвалжин будаа 387 га, үр тариа цайруулалт 790 га-гаас 1390.0 тонн, шууд хураалт 628 га-гаас 780,0 тонн, нийтдээ үр тариа хураалт 1415 га-гаас 2170.0 тонн, төмс 110 га-гаас 1595.0 тонн, хүнсний ногоо 106.3 га-гаас 1243.6 тонныг тус тус хураан аваад байна.

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуултын ажилд 162 өрхийн 28900 толгой хурга ишиг, 4200 толгой тугал дархлаажуулалтанд хамруулхаас 113 өрхийн 19480 толгой хурга ишиг, 3020 толгой тугал дархлаажуулалтанд хамруулаад байна.

Хүдэр сум:

Сумын Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж, өвөлжилтийн бэлтгэл байдал хангах, тендерийн ажлыг эрчимжүүлэх, сумдын Засаг дарга нарын зөвлөлдөх уулзалтын бэлтгэлийг хангах талаар болон Тарвагатай багийн нутагт баавгай айл рүү орж ирсэн тухай асуудал болон бусад асуудлыг хэлэлцсэн.

Энэ сарын 13, 14-ний өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдын Засаг дарга нарын зөвлөлдөх уулзалтыг тус суманд зохион байгууллаа.

Атрын 60 жилийн ойг угтан зүүн бүсийн ахмадын уулзалтыг зохион байгуулж, бүсийн ахмадын хорооны үйл ажиллагааны тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, урлаг, спортын тэмцээнийг явууллаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хангах хадлан бэлтгүүлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан ажиллаж байна. Иргэд аж ахуйн нэгжийн бизнесийн хадлан бэлтгэх 23 өргөдөл хүсэлтийг хүлээн авч, 7 аж ахуйн нэгж, 15 иргэнд 4 байршлын 1550 га талбайд хадлан бэлтгэхээр байна. Сумын өвсний нөөцөд 25 тонн өвс нийлүүлэх гэрээг 1 аж ахуйн нэгж 150 боодол, 1 иргэн 50 боодол өвс нийлүүлэхээр тогтож гэрээг байгуулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 200 тонн хадлан бэлтгээд байна.

Сумын ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлтэд ажиллах техникийн засвар, ургац хүлээн авах үтрэм, зоорь агуулахын засвар үйлчилгээ, цэвэрлэгээг зохион байгуулж, бэлтгэл хангалт 90 хувьтай байна. Ургац тогтоолтын ажлын хэсэг га-аас авах ургацын хэмжээг 11 цн-ээр тогтоосон. 9-р сарын 25-ны байдлаар сумын хэмжээнд төмс 12 га-гаас 150 тонн, хүнсний ногоо 32 га-гаас 268 тонн, рапс 30 га-гаас 32 тонн тус тус хураан аваад байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх заалтын дагуу амьд мал, мал амьтны шилжилт хөдөлгөөн, отор нүүдэлд хяналт тавих, сумын ИТХ-ын 34,85-р тогтоолыг тус тус үндэслэн сумын Засаг даргын А/121 дугаар захирамжаар сумаас мал оруулахыг хориглох тухай захирамжийг ханган ажиллах ажлын хэсэг байгуулагдан, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумаас иргэн Буяннэмэхийн малаас 12 үхэр, иргэн Олзвойн үхрээс 12, Сухбаатар сумын иргэн Оюунтунгалагаас 51 нийт 79 толгой үхэр тус тус тууварлагдан орж ирсэнийг буцаан гаргах, 10 хоногийн албан мэдэгдэлийг ажлын хэсгээс өгч тогтоол шийдвэрийг танилцуулах ажил хийлээ.

Сумын хэмжээнд бруцелёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг сумын Засаг даргын А/117 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг МЭҮН-тэй хамтран цаг хугацаанд нь тарилгын ажлыг хийж бодын төл 1900, богийн төл 8400 толгой хамрагдсан.

“Хаягжуулалтын тухай хууль”-ын дагуу шинэ хаягаар 13 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад кадастрын зургаар үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр өмчлөх эрхээ шилжүүлж буй иргэдийн өргөдлийг хүлээн авч эрх шилжүүлэх үйл ажиллагааг хийж, 1 иргэн, 1 аж ахуй нэгжид гэрчилгээ олгож ажиллалаа.

Сумын ИТХ-ын 120 дугаар тогтоолоор нийт 23.550 шоо метр мод хуваарилагдаснаас 9 сарын байдлаар хэрэглээний 8597 шоо метр, түлээний 3580 шоо метр мод бэлтгэгдсэн байна.

Тайлант сард аймгийн МХГ-ын 2019.01.03-ны 18-04-003/02 “Хяналт шалгалт хийх тухай” удирдам, сумын Засаг даргын 2019 оны 6-р сарын 28-ны өдрийн А/99 тоот “Ойгоос мод бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд БОХУБайцаагч, Ойн анги, Байгаль хамгаалагч, Хэсгийн байцаагч нар хамтран Сайдын ам, Бумбат, Тарвагатай, Шанд, Сөдтэй, Уялага чиглэлд төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг 3 удаа хийсэн.

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх “Хоггүй цэвэр, монгол” аяны хүрээнд Тарвагатай 1-р багт байрлах хогийн цэгийн ойр орчмын хогийг түрж цэвэрлэсэн ба сумын Засаг даргын тамгын газрын албан

хаагчид дошинт гүүр болон унаган толгойн ойр орчмын 15 км замын хогийг цэвэрлэн төв гүүр болон хүдэр хаалгыг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэв.

2019-2020 оны хичээлийн жилийн нээлтийг 9-р сарын 01-ний өдөр зохион байгуулж, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Сургуулийн дээд доод давхарын гэрлүүдийг сольж, шинээр 12 гэрлийн суурь нэмж, бага, дунд, ахлах 19 ангийн хаалгыг сольсон. Мөн “Дэлхийн зон олон улсын байгууллага”-аас тус сургуулийн ариун цэврийн байгууламжийг шинээр барьж өгөхөөр тендерийг зарласан, сумын 18,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Гадаад хэлний кабинет”-ийг шинээр тохижуулах ажлыг хийгдэхээр төлөвлөөд байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, үр хүүхэд ач зээ нарт хүндэтгэл үзүүлэх, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг сурталчлан таниулах үйл ажиллагааг сумын ИТХ-аас 9-р сарын 9, 10-ны өдрүүдэд зохион байгуулж, “Мартах эрхгүй, Давтах эрхгүй” баримтат киног ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад үзүүлсэн.

“Мэргэжил сонголт”-ын талаар 12 дугаар ангийн 2 бүлэгт дунд, ахлах ангийн багш нарай хамтран суралцагч, эцэг эхэд, тус бүрт нь хичээл сонголтын талаар ажил мэргэжлийн тухай, ярилцлага таницуулга хийж, эцэг эхэд мэргэжил сонголтын гарын авлага, брошур тарааж, эцэг эх, суралцагчтай гурвалсан гэрээ байгуулж ажилласан.

Сумын цэцэрлэг хичээлийн жилийн бэлтгэлийг хангах, Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж хүлэмж байгуулан өргөст хэмх 21.8 кг, улаан лооль 28кг, 8 бүлэг туршилтын талбайд 8 төрлийн хүнсний ногоо тариалж 126 кг ургац хураан авч хүүхдийн хүнсний болон сургалтын хэрэгцээнд ашиглаж байна. Мөн байгууллагын хэмжээнд 276м² талбайд цэвэрлэгээ, будаг, замаск, 780 м² талбайд угаалга цэвэрлэгээ, гадаа талбайд 22 төрлийн модон тоглоом, биеийн тамирын сургалтын хэрэглэгдэхүүнд засвар үйлчилгээ хийж, гал тогоо, 6 бүлгийн урсгал засварт эцэг эх, бусад хандиваас 1500.0 төгрөг зарцуулсан.

Цэцэрлэгийн 8 бүлгийн 218 хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэтгилэх үзлэг шинжилгээнд хамруулан хүлээн авч сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтыг зохион байгуулж байна.

ДЗОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөгжлийн хөтөлбөрийн төслөөр 6.994.300 төгрөгийн төслөөр “Саммит компьютер технологи” ХХК цэцэрлэгийн өргөтгөлийн бүлгүүд, коридорт 6 ш, барилгын гадна талд 2 ш, нийт 8 камерыг суурилуулж, эцэг эхчүүд хүүхдийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг хянах боломжийг бүрдүүлж, хүүхдийн орчны аюулгүй байдлыг хангасан.

Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 05 тоот тогтоолоор батлагдсан “Биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх, багш, ажилтны эрүүл мэнд, бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор “Зүүн бүсийн СӨБ-ын байгууллагуудын спортын бага наадам-2019” арга хэмжээг 9-р сарын 14-нд Бугант тосгоны 1-р цэцэрлэг дээр зохион байгуулсан.

Сумын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлж, тайлант сард 14 хүнийг хэвтүүлэн эмчилж, жирэмсний хяналтанд нийт 32 эх хянагдаж, саа өвчний эсрэг уудаг вакцинд 15,Тавт вакцинд 15,Улаанбурхан,гахайн хавдар, улаануудын вакцины 1-р тунд 3, Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын вакцины 2-р тунд 16, В гепатит “А” 1-р тунд 7, 2-р тунд 16 хамруулсан.

Сумын ахмадын хороотой хамтран ахмад настангуудыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж 27 хүнд DVD-ээр артерийн даралт ихдэх,хачигт халдвар,чихрийн шижингийн талаар сургалт хийж, 5 төрлийн шинжилгээнд 32 ахмад настанг хамруулж, зөвлөгөө өгч ажиллав.

Нóííí ð¿¿õüä, çàëóó÷óäüí äóíä, даралтат хөгжмийн äóäóéíáíç òíäòíë ðè÷úüë¿¿ëüí òýáíëë äâýàç чадварыг íúí ð°äæ¿¿ëж морин хуурын 10 сурагч, тогтмол бусаар 6 сурагч, ятга хөгжмийн 5 сурагч, нийт 19 сурагч хичээллэж байна.

Түшиг сум:

2019-2020 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг 09 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, хүүхэд, багачууд дуу хуурын дээжээ өргөлөө. Энэ хичээлийн жилд 1 дүгээр ангид 46 суралцагч суралцаж байна. Боловсрол, Соёлын урлагийн газрын 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан үзэсгэлэн арга хэмжээнд оролцож, орон нутгийн онцлог, зан заншил, орон нутаг судлах танхимд хадгалагдаж буй түүх соёлын дурсгалт зүйлсийг танилцууллаа.

Аймгийн эдийг засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2020 оны үндсэн чиглэлд тусгах саналыг боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллого, байшин, орон сууцны 2019 оны тооллогын бэлтгэл ажлыг хангаж, “Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлт-2019” аяныг багуудын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нар болон Хилийн 0243 дугаар ангийн Штабын дарга дэд хурандаа Б.Гантөмөр, 2 дугаар заставын дарга, ахмад Б.Мөнгөнбаяр хамтран иргэдтэй уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар хил орчмын бүс нутгаас түлшний зориулалтаар мод бэлтгэх, хадлан бэлтгэх, байгалийн дагалт баялаг ашиглах зэрэгт иргэн хилчдийн хоорондын маргааныг хэрхэн шийдвэрлэх, мэдээ мэдээллийг хэрхэн солилцох талаар ярилцаж шийдвэрлэлээ.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд 5935 тонн өвс, 315 тонн ногоон тэжээл, 1583 тонн үйлдвэрийн тэжээл, 3240 тонн байгалийн хадлан бэлтгэсэн.

Тайлант хугацаанд сумын эрүүл мэндийн төв 123 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх 53 буюу 43,08%, гэрийн идэвхтэй эргэлт 30 буюу 24,3 хувьтай байна. Эмнэлэгт 6 хүнийг хэвтүүлэн эмчилж, 2 эх төрснөөс 1 эхийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд төрүүлсэн. Товлолт дархлаажуулалтанд 13 х/т вакцин дархлаажуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гараагүй. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд 120 хүн хамрагдахаас 92 иргэнийг хамруулж хепатит В,С вирустэй 11 хүн илэрч, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

Энэ сард сумын иргэний бүртгэлд төрөлт 2, эцэг тогтоолт 1, нас баралт 1, шилжин ирсэн 3, иргэний үнэмлэх олголт 3, биеийн давхцахгүй өгөдлийн бүртгэл 3 бүртгэгдлээ.

Цагааннуур сум:

2019-2020 оны хичээлийн жилд сумын Ерөнхий боловсролын сургууль 77 багш ажиллагсад, 1006 суралцагчтайгаар ажиллаж байна. Үүнээс шинээр 1 дүгээр ангид 141 сурагч элсэн суралцаж байна.

Сумын сургуулийн өмнөх байгууллагад 31 багш ажилчид, 7 бүлэгт 271 хүүхэд хүмүүжиж байна.

Тайлант сард “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа” хөтөлбөрийн хүрээнд энэ сарын 17-ны өдөр Мандал сумын Засаг даргын Тамгын газарт туршлага судлах арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд энэ үеэр “Нийгмийн манлайлал-Хувь хүний хөгжил” сэдэвт сургалтанд 11 хүнийг хамруулсан.

Сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв хамтран байнгын асаргаатай иргэдийн асран хамгаалагчдад нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн даатгал, цахим даатгалын талаар мэдээлэл өгч, сумын 387 ахмад настанг 47 аж ахуйн нэгжид харъяалуулан өгсөн.

Сумын төвийн доторх 1,3 км замаас үргэлжлүүлэн 200 м хамуу хучилттай авто замын ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд гүйцэтгэгчээр “Есөн эрдэнэ” ХХК шалгаран гүйцэтгэж байна.

Ургац тогтоолтын урьдчилсан дүнгээр энэ онд нийт 25445 га талбайгаас улаан буудай хураан авахаар тооцсон бөгөөд 9-р сарын 23-ны байдлаар 8 аж ахуйн

нэгж ургац хураалтандаа орж, 2887 га талбайг ангилан, 1744 га талбайг цайруулж, 564 га талбайг шууд хурааж, нийт 2308 га талбайгаас 3500 тонн буюу га-гаас дунджаар 15,2 цн ургац хураан авсан.

Тариалангийн талбайг мал тэжээвэр амьтадаас хамгаалах талаар “Баяндулаан уул, Товхонхан”, “Сэлэнгэ тариа”, “Номунхан”, “Атар трейд” ХХК-ий удирдлагуудтай санал солилцон ажиллаж байна.

“Шилмэл мал-2019” Улсын үзэсгэлэн худалдаанд тус сумын “Сэлэнгэ тариа” ХХК-ий 4 өсвөр үхэр оролцон шилдэг хээлтүүлэгчийн дэд байрын шагналыг авсан.